



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэгт тус тус заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус хүргүүлэхийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Сарансүх)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-Эрдэнэ), Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд (Ж.Ганбаатар), Ашигт малтмал, газрын тосны газрын дарга (албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал) нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон тайлагнаж ажиллахыг Санхүү-нийцлийн аудитын газар (Ц.Наранчимэг)-т даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (Д.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

Агуулга

**Тайланг бэлтгэсэн:
ҮАГ-ын Санхүү-
Нийцлийн аудитын
газар:**

МУЕА-ын орлогч
Я.Сарансүх

СНАГ-ын захирал,
тэргүүлэх аудитор
Ц.Наранчимээ

Аудитын менежер
Д.Отгонбаяр

Ахлах аудитор
Д.Жаргалсайхан
Аудитор

Ц.Цэрэннамжил
Ц.Батсүх
Ж.Мөнхтуул

2023 оны 1 дүгээр сар

**Тайланг ҮАГ-ын вэб
сайтаас үзнэ үү.**
www.audit.mn

Аудитын тайлан
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
261749, 260949
дугаарын утас, факсаар
харилцана уу.

Хаяг:

Үндэсний аудитын
газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3
Засгийн газрын
ІҮ байр
Улаанбаатар хот
15160
Монгол Улс

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	1
Агуулга	2
Товчилсон үгийн жагсаалт	3
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	3
Аудит хийх үндэслэл	4
Аудитын зорилт	4
Аудитын хамарсан хүрээ	4
Аудитын арга зүй	4
Үндсэн мэдээлэл	5-6
Бүлэг 1. Гэрээлэгчдийн холбогдох хууль тогтоомж, БХГ-д нийцээгүй 2,937,802.0 ам долларын өнз-ыг хасаж баталгаажууллаа.	7-11
1.1. Гэрээлэгчид ӨНЗ-ыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байна.	7-9
1.2. Гэрээлэгчид холбогдох хууль тогтоомж, БХГ-ээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүй байна.	9-11
Бүлэг 2. Төрийн захиргааны холбогдох байгууллага нь гэрээлэгчийн хайгуулын үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг гэрээ, хууль тогтоомжид заасны дагуу бүрэн хэрэгжүүлээгүй байна.	12-16
2.1. АМГТГ нь гэрээлэгчдийн жилийн төлөвлөгөө, төсвийг батлахдаа коронавируст халдварын цар тахлын үеийн нөхцөл байдлыг харгалзаагүй, бодитоор үнэлээгүй байна.	12-13
2.2. Газрын тосны тухай хуулийн 37-р зүйлийн 37.1-д заасны дагуу АМГТГ-ын гүйцэтгэх хяналт шалгалт санхүүгийн 1-2 жилийн хоцролттой байна.	13-15
2.3. Газрын тосны салбарт мөрдөгдөж байгаа журмуудын зохицуулалтыг уялдуулах, шинэчлэх шаардлагатай байна.	15-16
Дүгнэлт	17
Зөвлөмж	18-19
Хавсралт 1	20-28
Холбогдох байгууллагын санал болон саналд өгөх тайлбар	29-43

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс /хуучин нэрээр/
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
ГТГ	Газрын тосны газар
ГТТХ	Газрын тосны тухай хууль
МАК	Монголын алт компани
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ӨНЗ	Өртөг нөхөгдөх зардал
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УУС	Уул уурхайн сайд /хуучин нэрээр/
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦХХХЯ	Цахим хөгжил, харилцаа холбооны яам

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	2019-2020 онд хайгуулын ажил гүйцэтгэсэн гэрээлэгчдийн мэдээлэл
Хүснэгт 2	Гэрээлэгчдийн хайгуулын ажлын ӨНЗ-ыг баталгаажуулсан дүн
Хүснэгт 3	Шунхлай энерги ХХК-ийн 2015 оны хайгуулын ажилд зарцуулсан ӨНЗ-ын мэдээлэл
Хүснэгт 4	Гэрээлэгчдийн гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн гүйлгээний дүн
Хүснэгт 5	Хууль болон БХГ-д заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсийг 2022 оны 12 дугаар сарын байдлаар төлөөгүй гэрээлэгчид
Хүснэгт 6	Гэрээлэгчид 2019-2020 онд төлөвлөгөө, төсөв батлуулсан байдал
Хүснэгт 7	Төлөвлөгөө, төсвөө батлуулсан боловч хайгуулын ажил хийгээгүй гэрээлэгч

Аудит хийх үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, 37.3-т тус тус заасныг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, МҮЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан ТАБ-ын 2022 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн 2019-2020 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнасан эсэхийг хянан баталгаажуулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэлээ.

Аудитын хамарсан хүрээ

Аудитаар Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу АМГТГ-аас ирүүлсэн хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтийн хүрээнд 2019-2020 онд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан Капкорп Монголиа ХХК, Монголын алт /МАК/ ХХК, Макс Ойл ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК-уудын 6 талбай, болон 2015-2016 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан Шунхлай энержи ХХК-ийн 1 талбай, нийт 7 талбайд батлагдсан төлөвлөгөө, төсөв ӨНЗ-ын тайлан, холбогдох бусад баримт материал, үйл ажиллагааг хамруулав.

Мөн УУХҮЯ, АМГТГ зэрэг төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааг хамруулан, бүтээгдэхүүн хуваах гэрээнд оролцогч талуудын чиг үүргийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шаардлагатай баримт материалыг түүвэрлэн шалгалаа.

Өвлийн хүйтэн сэрүүний улиралд аудитыг гүйцэтгэж, хайгуулын талбай цасанд хучигдсан нөхцөл таарснаас өрөмдлөг хийсэн газруудад байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг хууль тогтоомжийн дагуу хийсэн эсэх, өрмийн явцад гарсан аюултай хог хаягдлыг стандартын дагуу саармагжуулж, хоргүйжүүлсэн эсэхийг нягтлах хээрийн судалгааны ажил үр дүн багатай гэж үзээд дараагийн аудитаар эрсдэл тооцож авч үзэхээр хязгаарласан болно.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4000, 4001, МҮЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” болон холбогдох заавар, аргачлалыг баримтлан гүйцэтгэв.

Гэрээлэгчийн хайгуулын талбайн 2019, 2020 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөж, хууль журмын дагуу гүйцэтгэсэн эсэх, хайгуулын ажлын хөрөнгө оруулалт өртөг нөхөгдөх зардлыг үнэн зөв бүртгэж тайлагнасан эсэхийг санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн ерөнхий журнал, ерөнхий дэвтэр болон анхан шатны баримттай нь тулган баталгаажуулах горимыг хэрэгжүүлсэн.

Мөн холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тайлбар авах, газар дээр нь бодит гүйцэтгэлтэй тулган шалгах, батлагдсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлыг АМГТГ хянаж, хүлээн авсан баримт материалыг нягтлах зэргээр нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Үндсэн мэдээлэл

Газрын тосны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг 1991 оны Газрын тосны тухай хууль, “БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-аар зохицуулж ирсэн бөгөөд 2014 оноос Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж байна.

Мөн 2020 онд тус хуулийн нэмэлт өөрчлөлтөөр газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, санхүүгийн тайланг АМГТГ-аас хянан шалгаж, гаргасан тайлан дүгнэлтийг ТАБ-д хүргүүлснээр аудит хийж, баталгаажуулах зохицуулалт тусгагдсан.

Тухайн зохицуулалтын хүрээнд АМГТГ-ын даргын 2021 оны А/132 дугаар тушаалаар 2019-2020 онд уламжлалт болон уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардлыг хянан шалгаж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг томилон ажиллуулсан байна.

Тус Ажлын хэсгийн гүйцэтгэсэн хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтийг АМГТГ-ын 2021 оны 2/5945, 2022 оны 2/227 дугаар албан бичгээр ҮАГ-т ирүүлсний дагуу холбогдох анхан шатны баримт материал, гэрээлэгчдийн гаргасан тайлан, мэдээнд тулгуурлан аудит хийсэн.

Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 33 талбай ялгаснаас 2020 оны байдлаар Засгийн газрын шийдвэрийн дагуу АМГТГ-аас 23 талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах БХГ-г 20 гэрээлэгчтэй байгуулж, 10 талбай нээлттэй буюу БХГ-г байгуулаагүй байна.

Тус аудитад 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан дараах 6 гэрээлэгчийн 7 талбайг хамруулсан.

Хүснэгт 1. 2019-2020 онд хайгуулын ажил гүйцэтгэсэн гэрээлэгчдийн мэдээлэл.

№	Гэрээлэгч	Талбай	Хийсэн ажил
2019 он			
1	Капкорп	Богд IV	Байгаль орчны хяналт шинжилгээ, талбай буцаалт /бүтэн/
2	Монголиа ХХК	Онги V	БОННУ, талбай буцаалт /хэсэгчлэн/ Цооногийн дараах судалгаа
3	Жи Өү Эйч ХХК	Номгон IX	131.3 тууш.км чичирхийллийн судалгааны ажил, 3 цооног 1800 тууш.м (400+ 800+600)
4	Монголын алт /МАК/ ХХК	Төхөм X (урд)	625.9 тууш.км чичирхийллийн судалгааны ажил
5	Петроматад ХХК	Матад XX	БОННУ, Цооногийн дараах судалгаа, Өмнөх чичирхийллийн судалгааны ажилд дахин боловсруулалт хийсэн, 3 цооног 7510 тууш.м (2960+ 2000+2550)
6	Макс Ойл ХХК	Арбулаг XXIX	Байгаль орчны хяналт шинжилгээний ажил
2020 он			
7	Жи Өү Эйч ¹ ХХК	Номгон IX	Лаборатори, шинжилгээний ажил, Геологийн загварчлал боловсруулах, 105.9 тууш.км чичирхийллийн судалгааны ажил, 7 цооног 3280 тууш.м (580+400+ 4*500+300)

Мөн аудитын төлөвлөгөөнд тусгасны дагуу 2015-2016 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан хэдий ч ӨНЗ-ыг нь баталгаажуулаагүй /холбогдох мэдээллээ ирүүлээгүй/ үлдсэн Шунхлай энерги ХХК, Импайр газ Монголиа ХХК, Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК-уудыг тус аудитад хамруулж, Шунхлай энерги ХХК-

¹ Жи Өү Эйч ХХК нь Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “уламжлалт бус газрын тос” гэж байгалийн битум, шатдаг занар, тослог элс, хийтэй элс, хийтэй занар, нүүрсний давхаргын метан хийг” гэж заасны дагуу уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулдаг.

ийн 2015 онд хийсэн хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн.

Дараагийн аудитаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "хөрөнгө оруулалт" гэж *“Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг...”* гэж заасны дагуу гэрээлэгчийн хөрөнгө оруулалтын асуудлыг эрсдэлд тооцон авч үзэхээр шийдвэрлэлээ.

БҮЛЭГ 1. ГЭРЭЭЛЭГЧДИЙН ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БХГ-Д НИЙЦЭЭГҮЙ 2,937,802.0 АМ ДОЛЛАРЫН ӨНЗ-ЫГ ХАСАЖ БАТАЛГААЖУУЛЛАА.**1.1. Гэрээлэгчид ӨНЗ-ыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байна.**

1.1.1. Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1² болон Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 11.2³-т заасны дагуу АМГТГ-аас холбогдох хяналт шалгалтыг хэрэгжүүлж, 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн ӨНЗ-аас нийт дүнгээр 2,733,471.0 ам.долларын хасагдах зардал тооцсон тайлан, дүгнэлт гаргаж ирүүлсэнд аудит хийж, холбогдох анхан шатны баримт, нотлох зүйлсэд үндэслэн аудитаар 2,937,802.0 ам.долларыг ӨНЗ-аас хасаж, баталгаажуулахаар шийдвэрлэлээ. Дэлгэрэнгүйг хавсралт №1-д үзүүлэв.

1.1.2. Аудитын хамрах хугацаанд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан 6 гэрээлэгчийн 7 талбайд зарцуулсан ӨНЗ-аас аудитаар хасаж, баталгаажуулсан дүнг тоймлон гэрээлэгч бүрээр танилцуулбал:

Хүснэгт 2. Гэрээлэгчдийн хайгуулын ажлын ӨНЗ-ыг баталгаажуулсан дүн.

/ам.доллар/

Гэрээлэгч компани	Талбайн нэр	Гэрээлэгчдийн тайлагнасан ӨНЗ-ын дүн	АМГТГ-ын тооцооллоор		Хассан дүн	Баталгаажуулсан нийт ӨНЗ
			Хассан дүн	Нийт ӨНЗ		
1	2	3	4	5	6	8=3-6
Капкорп Монголиа ХХК	Богд IV	675,755.3	207,555.0	491,610.3	222,976.6	475,417.6
	Онги V	771,452.6	211,091.0	588,379.7	236,896.8	561,283.6
Монголын алт /МАК/ ХХК	Төхөм X (урд)	1,067,421.0	103.0	1,691,838.8	37.8	1,120,752.4
Макс Ойл ХХК	Арбулаг ХХIX	60,506.0	11,372.0	54,074.0	21,527.5	40,927.4
Петроматад ХХК	Матад ХХ	12,942,945.4	1,181,510.0	12,236,186.0	1,181,528.3	11,985,820.6
Жи Өү Эйч ХХК /2019 он/	Номгон IX	1,392,686.8	670,711.0	758,074.5	696,015.7	731,504.6
2019 оны дүн		16,910,767.0	2,282,342.0	15,820,163.2	2,358,982.7	14,915,706.2
Жи Өү Эйч ХХК /2020 он/	Номгон IX	1,584,155.0	451,129.0	1,189,677.3	578,819.3	1,055,602.5
2020 оны дүн		1,584,155.0	451,129.0	1,189,677.3	578,819.3	1,055,602.5
Нийт дүн		18,494,922.0	2,733,471.0	17,009,840.5	2,937,802.0	15,971,308.7

Эх сурвалж: АМГТГ-ын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/5330 дугаар албан бичиг

Тайлбар: Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын дүнд захиргааны нөхөгдөх зардлын дүн ороогүй. АМГТГ-ын тооцоолсон болон аудитаар баталгаажуулсан ӨНЗ-ын дүнд Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6⁴-д заасан захиргааны зардлын дүнг оруулсан болно.

1.1.3. Гэрээлэгчид 2019-2020 онд батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлсэн 659,904.8 ам.доллар, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 2,020,808.4 ам.доллар, БХГ болон холбогдох журамд ӨНЗ-д үл тооцохоор заасан 257,089.0 ам.долларын зардлыг ӨНЗ-д оруулж тайлагнасан нь Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүртгэл, тооцооны журам болон БХГ-ний холбогдох заалтыг зөрчсөн байна. Гэрээлэгчдийн захиргааны зардлыг БХГ-ний дагуу дахин тооцоолж 83,867.7 ам.доллар хасан, 414,188.7 ам.доллаароор баталгаажууллаа. Үүнд:

✚ Капкорп Монголиа ХХК-ийн гэрээт Богд IV талбайд батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлсэн 3,591.2 ам.доллар, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 219,385.4 ам.доллар, БХГ-д

² Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага анхан шатны баримтад үндэслэн гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ ... хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.

³ Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, ... анхан шатны баримт материалд үндэслэн хянан шалгаж, дүгнэлт гаргана.

⁴ гэрээлэгчийн захиргааны зардал нь тухайн жилийн өртөг нөхөх зардлын тав хүртэл хувь байх

- заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож хассан захиргааны зардал 13,058.6 ам.доллар;
- ✚ Капкорп Монголиа ХХК-ийн гэрээт Онги V талбайд батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлсэн 3,204.8 ам.доллар, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 233,962.0 ам.доллар, БХГ-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож хассан захиргааны зардал 10,378.9 ам.доллар,
 - ✚ Монголын алт /МАК/ ХХК-ийн гэрээт Төхөм X (урд) талбайд БХГ-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож хассан захиргааны зардал 1.9 ам.доллар, бусад төрлийн зөрчилтэй 37.8 ам.доллар;
 - ✚ Макс ойл ХХК-ийн гэрээт Ар булаг ХХХ талбайд санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 4,730.5 ам.доллар, БХГ-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож хассан захиргааны зардал 3,858.2 ам.доллар, бусад төрлийн зөрчилтэй 16,797.0 ам.доллар;
 - ✚ Жи Өү Эйч ХХК-ийн гэрээт Номгон IX талбайд 2019 онд батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлсэн 16,848.5 ам.доллар, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 673,346.5 ам.доллар, БХГ-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож хассан захиргааны зардал 34,800.8 ам.доллар, бусад төрлийн зөрчилтэй 5,820.7 ам.доллар;
 - ✚ Жи Өү Эйч ХХК-ийн гэрээт Номгон IX талбайд 2020 онд батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлсэн 136,126.9 ам.доллар, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 437,876.2 ам.доллар, БХГ-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож хассан захиргааны зардал 18,816.3 ам.доллар, бусад төрлийн зөрчилтэй 4,816.2 ам.доллар;
 - ✚ Петроматад ХХК-ийн гэрээт Матад ХХ талбайд батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлсэн 500,133.3 ам.доллар, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 451,777.8 ам.доллар, БХГ-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож хассан захиргааны зардал 2,953.2 ам.доллар, бусад төрлийн зөрчилтэй 229,617.3 ам.долларын зөрчил байна.

Иймд аудитаар Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7⁵, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 2.2.6⁶, 3.1.3⁷, болон дээрх компаниудтай байгуулсан БХГ-ний хавсралт Г-ийн 2.4.2⁸-д тус тус заасныг зөрчсөн дээрх зардлыг ӨНЗ-аас хасаж тооцлоо.

1.1.4. АМГТГ нь Капкорп Монголиа ХХК болон Петроматад ХХК-тай байгуулсан БХГ-ний 7.3.3-д “Гэрээлэгч нь тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй тохиолдолд Газрын тосны тухай хуульд заасан хариуцлага хүлээхээс гадна гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш 30 (гуч) хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад төлнө; Харин тухайн жилд гүйцэтгэх ажил үүргээс илүү ажил үүрэг гүйцэтгэж, төлөвлөснөөс илүү зардал гаргасан тохиолдолд дараа жилийн гүйцэтгэх ажил, зардалд шилжүүлэн тооцож болно” гэж батлагдсан төлөвлөгөө, төсвийг хэтрүүлсэн зардлыг бусад гэрээлэгчдээс ялгаатай байдлаар авч үзэхээр тусгасан нь МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын 3.1.3⁷-т нийцэхгүй байна. Иймд 2019 оны батлагдсан төлөвлөгөө төсвөөс хэтрүүлсэн Капкорп Монголиа ХХК-ийн /Богд IV талбай/ 3,591.2 ам.доллар, /Онги V талбай/ 3,204.8 ам.доллар, Петроматад ХХК-ийн /Матад ХХ талбай/ 500,133.3 ам.доллар нийт 506,929.3 ам.долларын зардлын асуудлыг БХГ болон хууль тогтоомжийн хүрээнд АМГТГ нь дараагийн хяналт шалгалтад хамруулах шаардлагатай байна.

Гэрээлэгчид батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлж байгаа нь ГТГ-ын даргын 2013 оны 28 дугаар тушаалаар баталсан Газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд

⁵ Гэрээлэгчийн тайлагнасан өртөг нөхөгдөх зардал санхүүгийн баримтаар нотлогдоогүй тохиолдолд өртөг нөхөгдөх зардалд тооцогдохгүй

⁶ Өртөг нөхөгдөх зардал нь анхан шатны баримтаар нотлогдсон байх ба анхан шатны баримт нь ажил, гүйлгээ гарсныг нотлох, бичгээр бүрдүүлсэн гэрээ болон нэхэмжлэх, төлбөрийн даалгавар, орлогын баримт, цагийн тооцоо, акт болон бусад нотлох баримтууд байна

⁷ Холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн, эсхүл гэрээнд зөвшөөрөөгүй зардал

⁸ Холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн эсхүл гэрээнд зөвшөөрөөгүй ангилалд хамаарах зардал

мөрдөх жишиг үнийг зах зээлийн ханштай уялдуулж шинэчлээгүйтэй холбоотой байх эрсдэлтэй байна.

1.1.5. Мөн аудитын төлөвлөгөөнд тусгасны дагуу 2015-2016 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан хэдий ч *“өмнөх онуудад хийгдсэн аудитад холбогдох мэдээллээ ирүүлээгүйгээс”* ӨНЗ-ыг нь баталгаажуулаагүй үлдсэн 3 гэрээлэгчийг аудитад хамруулан үзэхэд дараах 2 гэрээлэгчийн хувьд өмнөх онуудын ӨНЗ-ыг баталгаажуулах шаардлагагүй нөхцөл үүссэн байна. Үүнд:

- ❖ Импайр газ Монголиа ХХК нь 2015, 2016 онд хайгуулын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгөө, төсөв батлуулсан боловч үйл ажиллагаа явуулаагүй тул Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 232 дугаар тогтоолоор гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэрээлэгчтэй БХГ-г цуцлах эрхийг АМГТГ-ын даргад олгосны дагуу АМГТГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/85 дугаар тушаалаар Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцалсан;
- ❖ Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК нь 2015, 2016 онд хайгуулын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгөө, төсөв батлуулсан боловч орон нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч үйл ажиллагаа явуулаагүй, түүнээс хойш дахин төлөвлөгөө батлуулаагүй, ажил хийгээгүй тул АМГТГ-аас удаа дараа албан бичиг илгээсэн ч хариу ирүүлээгүй байна. Иймд АМГТГ-аас 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр БХГ-ний үүргээ биелүүлээгүй, санаачлагагүй, идэвхгүй, холбоогүй байдал удаан үргэлжилсэн тул Газрын тосны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, БХГ-ний 20.1.2 дахь заалтын дагуу БХГ-г цуцлах үндэслэл бүрдсэн талаар хандсан ч хариу ирүүлээгүй байна. Мөн тус гэрээлэгч компанийн БХГ-ний хугацаа 2023 онд дуусах бөгөөд УУХҮЯ-д гэрээний биелэлтийг бодит байдлаар дүгнэж гэрээг цуцлуулах шийдвэр гаргуулах талаар мэдэгдсэн байна.

1.1.6. Харин АМГТГ-аас 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 2/5434 дүгээр албан бичгээр Шунхлай энерги ХХК-ийн газрын тосны хайгуулын Сулинхээр ХХ талбайд 2015 онд хийсэн хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах хүсэлт ирүүлсний дагуу гэрээлэгчийн тухайн оны холбогдох тайлан, мэдээ, анхан шатны баримт, бүртгэлд тулган баталгаажуулалт хийж, аудитад хамруулсан.

Хүснэгт 3. Шунхлай энерги ХХК-ийн 2015 оны хайгуулын ажилд зарцуулсан ӨНЗ-ын мэдээлэл /ам.доллар/

Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	2015 он /ам.доллар/						
		Гэрээлэгчийн ирүүлсэн			Аудитаар			
		ӨНЗ-ын дүн	Захир-гааны зардал	Нийт ӨНЗ	Аудит аар хасагд-сан	ӨНЗ-ын дүн	Захир-гааны зардал	Батал-гаажсан нийт ӨНЗ
1,413,500.0	1,013,455.4	743,953.2	37,197.7	781,150.8	3,580.0	740,373.2	37,018.7	777,391.9

Хүснэгт 4-д харуулснаар тус гэрээлэгч нь газрын тосны хайгуулын Сулинхээр ХХIII талбайд 2015 онд нийт 1,413,500.0 ам.доллар зарцуулж, үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө, төсөв батлуулж 1,013,455.4 ам.долларын гүйцэтгэлтэйгээр тайлагнаж АМГТГ-т хүргүүлсэн байна. Аудитаар Шунхлай энерги ХХК-ийн ӨНЗ-ын гүйлгээнээс холбогдох хууль тогтоомж, БХГ-д нийцээгүй нийт 3,758.9 ам.долларыг хасаж баталгаажууллаа.

1.2. Гэрээлэгчид холбогдох хууль тогтоомж, БХГ-ээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүй байна.

1.2.1. Жи Өү Эйч ХХК-ийн гэрээт Номгон IX талбайн 2019, 2020 он, Капкорп Монголиа ХХК-ийн гэрээт Богд IV болон Онги V, Петроматад ХХК-ийн гэрээт Матад ХХ хайгуулын талбайн ӨНЗ-д тайлагнасан зардлаас нийт 1,573,874.4 ам.долларын гүйлгээг гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 4. Гэрээлэгчдийн гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн гүйлгээний дүн.

/ам.доллар/

№	Гэрээлэгч компани	Талбайн нэр	Оноор		Нийт
			2019	2020	
1	Капкорп Монголиа ХХК	Богд IV	96,105.3		96,105.3
2		Онги V	96,299.6		96,299.6
3	Петроматад ХХК	Матад ХХ	281,047.6		281,047.6
4	Жи Өү Эйч ХХК	Номгон IX	667,262.5	433,159.4	1,100,421.9
Нийт			1,140,715.0	433,159.4	1,573,874.4

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6⁹, 36-р зүйлийн 36.2¹⁰ дахь хэсэг, БХГ-ний 14.1.2¹¹ /Номгон IX/, 15.1.2 /Богд IV, Онги V, Матад ХХ/-т заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.13¹²-т заасны дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлж, гэрээлэгчид хариуцлага тооцох албан шаардлагыг АМГТГ-т хүргүүлээ.

1.2.2. Аудитад хамрагдсан гэрээлэгч компаниуд 2019, 2020 онд Газрын тосны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2¹³, БХГ-ний 13.1¹⁴, 13.4¹⁵, 13.5¹⁶-д заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлс нийт 2,867,962.3 ам.долларыг төлөөгүй байна. Харин аудитад тухайн гэрээлэгчдийн 2022 оны жилийн эцсийн байдлаар төлбөрийн үлдэгдлээр тооцоолоход төлөгдөөгүй дүн 4,799,703.2 ам.доллар байна.

Хүснэгт 5. Хууль болон БХГ-д заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсийг 2022 оны жилийн эцсийн байдлаар төлөөгүй гэрээлэгчид

/ам.доллар/

№	Компанийн нэр	Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн төлбөр	Сургалтын урамшуулал	Төлөөлөгчийг дэмжих үйл ажиллагааны дэмжлэг	Нийт
1	Капкорп Монголиа ХХК	Онги V	-	75,000.0	-	75,000.0
2	Шунхлай энерги	Сулинхээр XXIII	516,130.7	760,000.0	440,000.0	1,716,130.7
3	Монголын Алт ХХК	Төхөм-Х (Урд)	50,182.2	25,667.3	37,230.1	113,079.7
4	Макс ойл	Арбулаг XXIX	-	1,200,000.0	1,695,492.8	2,895,492.8
Нийт			566,312.9	2,060,667.3	2,172,722.9	4,799,703.2

Иймд АМГТГ-т Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т "... энэ хуулийн 30, 31, 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

1.2.3. Гэрээлэгчид БОАЖС-ын 2019 оны А/618 дугаар тушаалаар баталсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 2.9¹⁷-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө болон байгаль

⁹ хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах

¹⁰ Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнаа

¹¹ гэрээлэгч эсхүл оператор компани нь хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгана.

¹² Тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахдаа: 9.2. хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх ба уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах ... үүргийг зөрчсөн бол ... хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно

¹³ Хайгуулын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр ... төгрөг байна

¹⁴ Гэрээлэгч гэрээнд гарын үсэг зурсны урамшуулал: Гэрээлэгч нь 70,000 (далан мянга)-ын ам.долларыг гэрээт жил эхэлснээс хойш 60 (жар) хоногийн дотор улсны төсөвт шилжүүлнэ.

¹⁵ Сургалтын урамшуулал

¹⁶ Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг

¹⁷ тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ...газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхит ашигт малтмал хайх төслийн хувьд эрх бүхий байгууллагын баталсан хайгуулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна

орчны менежментийн төлөвлөгөөг уялдуулан боловсруулдаггүй, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Жи Өү Эйч ХХК-аас бусад гэрээлэгчид тухай жилийн хайгуулын ажлын төсөв, төлөвлөгөөнд тусгасны дагуу орчны хяналт шинжилгээ, дүйцүүлэн хамгаалах зэрэг үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлээгүй;
- Монголын алт (МАК) ХХК-ийн 2019 оны хайгуулын ажлын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах зардалд 65,000.0 ам.доллараар төсөвлөсөн хэдий ч нийт 21.9 ам.доллар /Монгол банкны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хаалтын ханш 2,734.3 төгрөг/ тайлагнасан байна. Мөн тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд тусгасан боловч ажлын гүйцэтгэлийн баримт материал байхгүй, байгаль орчны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна;
- Аудитад хамрагдсан гэрээлэгчид БОАЖС-ын 2019 оны А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2.9-д тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг газрын тос, уламжлалт газрын тос, цацраг идэвхит ашигт малтмал хайх төслийн хувьд хайгуулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна гэж заасныг хэрэгжүүлдэггүй нийтлэг зөрчилтэй байна.

Иймд Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2¹⁸-т заасны дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлж, хариуцлага тооцох албан шаардлагыг АМГТГ-т хүргүүлээ.

1.2.4. Гэрээлэгч Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК-ууд нь газрын тосны хайгуул, ашиглалт, бүтээн байгуулалт, татан буулгалтын үйл ажиллагаанд хамаарах гэрээ, тооцооны хуудас зэрэг санхүүгийн анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийг гадаад хэлээр үйлдэж, бүртгэсэн байна.

Энэ нь Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7¹⁹, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1²⁰, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан загварын дагуу АМГТГ болон хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгч хооронд байгуулсан БХГ-ний 14.1.1²¹, 15.1.1²², Газрын тосны бүртгэл тооцооны журмын 10.6²³-д тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Зөрчлийн тухай хуулийн 9.10 дугаар зүйлийн 1.2²⁴-т заасны дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлж, хариуцлага тооцох албан шаардлагыг АМГТГ-т хүргүүлээ.

¹⁸ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, ... бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно

¹⁹ Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаадын хуулийн этгээд... санхүү, татвар, хөдөлмөр... холбогдолтой баримт бичиг, мэдээллийг монгол хэлээр үйлдэнэ.

²⁰ Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нь нягтлан бодох бүртгэлээ монгол хэлээр хөтөлнө.

²¹ Жи Өү Эйч ХХК-ийн БХГ-ний 14.1.1-т гэрээлэгч эсхүл оператор компани нь нүүрсний давхаргын метан хийн хайгуул, газрын тосны хайгуул, ашиглалт, бүтээн байгуулалт, татан буулгалтын үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль тогтоомж болон энэхүү гэрээний дагуу монгол хэл дээр, шаардлагатай гэж үзвэл монгол, англи хэл дээр давхар хөтөлнө

²² Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК-ийн БХГ-ний 15.1.1-т гэрээлэгч эсхүл оператор компани нь газрын тосны хайгуул, ашиглалт, бүтээн байгуулалт, татан буулгалтын үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль тогтоомж болон энэхүү гэрээний дагуу монгол хэл дээр, шаардлагатай гэж үзвэл монгол, англи хэл дээр давхар хөтөлнө

²³ Гэрээлэгч, эсхүл оператор компани нь газрын тосны хайгуул, ашиглалт, бүтээн байгуулалт, татан буулгалтын үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг монгол хэл дээр, шаардлагатай гэж үзвэл монгол, англи хэл дээр давхар хөтөлнө.

²⁴ Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн этгээд ... холбогдолтой баримт бичгийг төрийн албан ёсны хэлээр хөтлөх журам зөрчсөн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

БҮЛЭГ 2. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА НЬ ГЭРЭЭЛЭГЧИЙН ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫГ ГЭРЭЭ, ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСНЫ ДАГУУ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

2.1. АМГТГ нь гэрээлэгчдийн жилийн төлөвлөгөө, төсвийг батлахдаа коронавируст халдварын цар тахлын үеийн нөхцөл байдлыг харгалзаагүй, бодитоор үнэлээгүй байна.

2.1.1. Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3 дахь заалт болон БХГ-д заасны дагуу гэрээлэгчид тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг АМГТГ-аар батлуулж, хэрэгжүүлэх зохицуулалттай.

Гэтэл 2019-2020 онд давхардсан тоогоор 17 гэрээлэгчийн 20 талбайд төлөвлөгөө, төсөв батлуулсан боловч 6 гэрээлэгчийн 7 талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулж, 13 гэрээлэгч төлөвлөгөө, төсөв батлуулаагүй, тухайн чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 6. Гэрээлэгчид 2019-2020 онд төлөвлөгөө, төсөв батлуулсан байдал /талбайн тоогоор/

Хугацаа	Төлөвлөгөө, төсөв батлуулсан	Үйл ажиллагаа явуулсан	Үйл ажиллагаа явуулаагүй	Үүнээс: Хайгуулын үйл ажиллагааг түр зогсоосон
2019 он	11	6	5	1
2020 он	9	1	8	8

Эх сурвалж: АМГТГ-ын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/5330 дугаар албан бичиг

2.1.2. Мөн АМГТГ нь гэрээлэгчдийн жилийн төлөвлөгөө, төсвийг батлахдаа цаг үеийн нөхцөл байдлыг бодитоор үнэлээгүй, тооцоо судалгаатай шийдвэр гаргаагүйгээс 2019 онд 5 гэрээлэгч, 2020 онд 8 гэрээлэгч жилийн ажлын төлөвлөгөө, төсөв батлуулсан хэдий ч дараах шалтгаануудын улмаас хайгуулын ажил гүйцэтгээгүй, зардал гаргаагүй байна.

Хүснэгт 7. Төлөвлөгөө, төсвөө батлуулсан боловч хайгуулын ажил хийгээгүй гэрээлэгч

/ам.доллар/

Гэрээлэгчийн нэр	Талбайн нэр	2019 он	2020 он	Тайлбар
		батлагдсан төсвийн дүн		
Монгол алт /МАК/ ХХК	Төхөм-Х (Урд)	-	15,271,059.9	2020 онд Ковид-19 улмаас ажил хийх боломжгүй болж, түр зогсолт олгох хүсэлт ирүүлсний дагуу АМГТГ-ын даргын 2020.08.11-ний өдрийн А/80 дугаар тушаалаар хайгуулын үйл ажиллагааг түр зогсоосон.
Макс ойл ХХК	Арбулаг ХХIX	-	957,000.0	
Зон хэн юу тиан ХХК	Галба XI	-	1,580,946.2	
Смарт-Ойл Инвестмент ХХК	Эргэл XII	7,710,516.1	7,710,516.1	2019 онд Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газраас ажиллах хүчний зөвшөөрөл олгоогүй тул ажил хийгээгүй.
Түмэн-Ойл ХХК	Баянтүмэн XVII	4,636,697.0	4,364,372.0	Шүүхийн маргаантай тул түр зогсолт олгох хүсэлт ирүүлсний дагуу АМГТГ-ын даргын 2020.01.16-ны өдрийн А/08 дугаар тушаалаар хайгуулын үйл ажиллагааг түр зогсоосон.
Петровис ресурс ХХК	T1	-	443,252.0	Ковид-19 улмаас ажил хийх боломжгүй болж түр зогсолт олгох хүсэлт ирүүлсэн. ГТТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.3-т заасны дагуу хайгуулын үйл ажиллагааг түр зогсоох хүсэлтийг УУХҮЯ-д уламжилсан. /Уламжлалт бус газрын тос/
	Богд IV		515,535.0	
	Онги V		528,230.0	
Шунхлай-Энержи ХХК	Сулинхээр XXXIII	244,500.0	-	Шүүхийн маргаантай тул ажил хийгээгүй.
Реново-Илч ХХК	Хар-Ус II	6,055,804.8	-	МУЗГ-ын 2022.09.05-ны өдрийн 337 дугаар тогтоол гэрээг цуцлах эрхийг олгосны дагуу АМГТГ-ын даргын 2022.09.28-ны А/109 тушаалаар БХГ-г цуцалсан.
Монголиа Велпэк Индастриал ХХК	Хэрлэн тохой ХХVIII	3,148,600.0	-	

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан гэрээлэгчид Газрын тосны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.12²⁵ дахь хэсэг болон БХГ-ээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүйд тооцогдох эрсдэлийг үүсгэж байна.

2.2. Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу АМГТГ-ын гүйцэтгэх хяналт шалгалт санхүүгийн 1-2 жилийн хоцролттой байна.

2.2.1. АМГТГ-ын даргын 2021 оны А/132 дугаар тушаалаар 2019, 2020 онд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардлыг хянан шалгаж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг томилон ажилласан байна.

Уг хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтээ Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу АМГТГ-ын 2021 оны 2/5945, 2022 оны 2/227 дугаар албан бичгүүдээр ҮАГ-т ирүүлсэн.

2.2.2. Аудитаар гэрээлэгчдийн холбогдох тайлан, мэдээ, анхан шатны баримтыг тулган баталгаажуулж, ирүүлсэн хяналт шалгалтын тайлан, дүгнэлтэд дүн шинжилгээ хийхэд АМГТГ нь дараах алдаа, зөрчил бүхий тайлан, дүгнэлт гаргасан байна. Үүнд:

- Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, **хөрөнгө оруулалт**, өртөг нөхөгдөх зардлын **хэмжээ**, **санхүүгийн тайлан**г хянан шалгаж...” гэж заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй. Тухайлбал: Ирүүлсэн хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтэд хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүгийн тайланг хянаж, шалгасан талаар дүгнэлт тусгаагүй;
- Санхүүгийн тайлангийн бичилтийн болон бүртгэлийн алдаатай тайлан хүлээн авч хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт гаргасан. Тухайлбал: зардлын дансны код, нэр зөрүүтэй, буруу бичилтийн залруулгын талаар хяналт шалгалтын тайланд тусгаагүй;
- Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хавсралтын 3.1.7.4.3-т “бутархай тоог бүхэл тооноос тусгаарлаж цэг тэмдэг ашиглаж дараах байдлаар бичнэ. Жишээ нь: 3,568.58 (гурван мянга таван зуун жаран найман бүхэл зууны тавин найм)” гэж заасныг баримтлаагүй, хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтдээ хөрөнгө оруулалт, зардлын дүнг тооны оронгийн нарийвчлалгүй, бүхэл дүнгээр тусгаснаас аудитаар тооцоолж гаргасан дүнгээс зөрүү үүссэн;
- Гэрээлэгчдийн хайгуулын үйл ажиллагаанд зарцуулсан зардлын холбогдох анхан шатны баримтыг дутуу үнэлснээс зарим ӨНЗ-ын дүнд зөрүү үүссэн. /Хүснэгт 2/

Иймд АМГТГ-аас гэрээлэгчийн тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүгийн тайландаа холбогдох мэдээллийг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдал зэрэг хуульд заасан мэдээллийг иж бүрэн хамруулсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, дүгнэлт тайлан гарган ТАБ-д ирүүлж байх шаардлагатай.

2.2.3. АМГТГ-ын хяналт шалгалтын тайланд нэр бүхий гэрээлэгчийн 2020 онд зарцуулсан зардлын гүйлгээг “он дамнасан зардал” гэсэн нэршлээр 2019 оны ӨНЗ-д оруулж тооцсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1²⁶, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 3.1.2²⁷-т заасанд нийцээгүй байна. Үүнд:

²⁵ Хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгэх үүргээ хоёр буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй тохиолдолд хайгуулын хугацааг сунгахгүй.

²⁶ Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

²⁷ нягтлан бодох бүртгэлийн аккрузал суурийн дагуу бүртгэсэн боловч төлөгдөөгүй аливаа зардал

- Монголын алт /МАК/ ХХК 543,957.0 ам.доллар /ҮАГ-т 2021 оны 2/5945, 2022 оны 2/227 дугаар албан бичгээр ирүүлсэн хяналт, шалгалтын тайлан/;
- Макс Ойл ХХК 2,365.0 ам.доллар /ҮАГ-т 2021 оны 2/5945, 2022 оны 2/227 дугаар албан бичгээр ирүүлсэн хяналт, шалгалтын тайлан/;
- Петроматад ХХК 244,322.0 ам.долларын буюу нийт 790,643.0 ам.доллар /ҮАГ-т 2021 оны 2/5945, 2022 оны 2/227 дугаар албан бичгээр ирүүлсэн хяналт, шалгалтын тайлан/.

Иймд АМГТГ-т дээрх гэрээлэгчдийн холбогдох үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлж, 2020 оны санхүүгийн жилээр тайлан дүгнэлтийг гаргаж, ТАБ-д ирүүлэх шаардлагатай.

2.2.4. АМГТГ-аас Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх тогтсон стандарт, заавар, журам байхгүй, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй, голчлон төрөлжсөн мэргэжлийн инженерүүдийн бүрэлдэхүүнтэй **түр Ажлын хэсэг** томилон санхүүгийн хяналт, шалгалтыг гүйцэтгэсэн нь тайлан, дүгнэлт үнэн зөв, үндэслэл бүхий байж чадахгүй байна.

Мөн АМГТГ-ын хяналт шалгалтдаа үндэслэсэн анхан шатны баримт материал бүрэн бус, тайлан, дүгнэлтэд тусгасан тооцоолол, дүн нь баримтаар нотлогдоогүй зэргээс гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг аудитаар баталгаажуулахад ирүүлсэн тайлан, дүгнэлт нь ач холбогдол, үр нөлөө багатай байсныг энэхүү аудитын тайланд тусгах нь зүйтэй гэж үзлээ.

2.2.5. АМГТГ нь гэрээлэгчээс хайгуулын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, тайлан, баримт материалыг тухай бүр авдаг ч хяналт шалгалтын үйл ажиллагаандаа ашигладаггүй, тухай бүр хяналт тавьдаггүй, үр дүнг тооцдоггүй байна. Үүнээс шалтгаалан холбогдох хяналт шалгалтыг түр Ажлын хэсэг томилон гүйцэтгүүлж, гэрээлэгчдээс дахин тайлан, мэдээллийг гаргуулан авч хугацаа алдаж байна.

Иймд АМГТГ-аас хууль тогтоомжид заасны дагуу гэрээлэгчдийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллах чиг үүргээ оновчтой зохион байгуулж, хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.2.6. Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу АМГТГ нь газрын тосны хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн *“...батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг”* хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа ТАБ-д ирүүлэх зохицуулалттай.

Гэтэл 2021, 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн дээрх үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хянаж шалгаж, дүгнэлт гаргасан тайланг одоог хүртэл ҮАГ-т ирүүлээгүй байна.

Үүнээс шалтгаалан Сангийн сайдын 2020 оны 46 дугаар тушаалаар баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, нэгтгэлийн мэдээллийн ашиглах журмын 4.3²⁸-д заасны дагуу гэрээлэгчид жилийн эцсийн санхүүгийн тайлангийн залруулга хийлгэж баталгаажуулах хугацаа өнгөрч, Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу ТАБ аудит хийж, баталгаажуулсан дүнгээр гэрээлэгчид санхүүгийн тайландаа *“...хөрөнгө*

²⁸ Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн залруулгыг дараа оны 12 дугаар сарын 20-ыг хүртэл, хагас жилийн санхүүгийн тайлангийн залруулгыг тухайн тайлант оныг дуустал харилцагч санхүүгийн байгууллага хийнэ.

оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо...” зэргийг тайланд залруулж баталгаажуулах боломжгүй байдлыг үүсгэж байна.

Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасны дагуу *“...аж ахуйн нээж, байгууллага нь эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ”* гэж заасныг газрын тосны хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчид хэрэгжүүлэх үүрэгтэй.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан загварын дагуу АМГТГ, хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгч нарын хооронд байгуулсан БХГ-д гэрээлэгчдийн холбогдох тайлан мэдээг Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү гэрээний дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнаж байгаа байдалд АМГТГ байнгын хяналт тавьж ажиллахаар заасан байна.

Дээрх зохицуулалтын дагуу Ашигт малтмал, газрын тосны газар нь гэрээлэгчдийн *“хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо”* зэргийг санхүүгийн тайландаа үнэн зөв бүртгэж тайлагнасан байдалд тухайн санхүүгийн жилийн дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө хяналт хэрэгжүүлсэн байхаар байна.

Иймд АМГТГ-ын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг УУХҮС-д өгч, 2020-2021 онд хайгуулын үйл ажиллагаагаа тайлагнасан гэрээлэгчдийн холбогдох үйл ажиллагаанд хуулийн дагуу хийсэн хяналт шалгалтын тайлангаа ирүүлээгүй, 1-2 санхүүгийн жилээр хугацаа хоцролттой байгаа зөрчлийг арилгах албан шаардлагыг АМГТГ-т хүргүүлээ.

Мөн АМГТГ-аас гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт, ӨНЗ зэрэгт хяналт, шалгалт хийж, тайлан дүгнэлтийг ТАБ-д хүргүүлэх хугацааг дээр дурдсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжтой уялдуулан Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1²⁹, мөн Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын 11.6³⁰-д тодорхой тусгах зөвлөмжийг МУЗГ-т өгөхөөр шийдвэрлэлээ.

2.3. Газрын тосны салбарт мөрдөгдөж байгаа журмуудын зохицуулалтыг уялдуулах, шинэчлэх шаардлагатай байна.

2.3.1. Газрын тосны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт зааснаар *“Гэрээлэгч хайгуул, ашиглалтын үр дүнгийн тайлан, анхдагч мэдээ материалыг хуанлийн тухайн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор...”* АМГТГ-т хүлээлгэж өгөх зохицуулалттай.

Гэтэл УУС-ын 2015 оны 49 дүгээр тушаалын хавсралтаар баталсан *“Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага”* журмын 15.1.9³¹-т *“...дараа оны 1 дүгээр сард*

²⁹ Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага анхан шатны баримтад үндэслэн гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ,... хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.

³⁰ Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь шалгалтын дүгнэлтийг гэрээлэгч, эсхүл оператор компанийн саналын хамт Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.

³¹ Гэрээлэгч нь БХГ болон тухайн жилд төлөвлөсөн төлөвлөгөө, төсвийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын хэрэгжилтийн тайлангаа дараа оны 1 дүгээр сард багтаан Төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байна

багтаан ...”, 15.1.10³²-д “...дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор” гэж тусгасан хугацаа нь бодит гүйцэтгэлээр зөрүүтэй байдлыг үүсгэж байна.

Иймд гэрээлэгчийн хайгуул, ашиглалтын үр дүнгийн тайлан, мэдээ болон тухайн жилд төлөвлөсөн төлөвлөгөө, төсвийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын хэрэгжилтийн тайланг АМГТГ-т хүлээн авч, хянаж үнэлэх, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх хугацааг уялдуулан дээрх журмуудад оновчтой тусгах шаардлагатай.

2.3.2. Газрын тосны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1³³-т гэрээлэгч тухайн жилд оруулсан хөрөнгө, төлсөн татвар төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсний хэмжээ зэргийг дараа оны нэгдүгээр улиралд багтаан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэхээр заасан боловч хуулийн тус заалтыг хэрэгжүүлдэггүй байна.

Мөн уг хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т “Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана” гэж заасан.

Гэвч гэрээний нөгөө тал болох АМГТГ гэрээлэгчдийн хайгуулын ажилд хийсэн хөрөнгө оруулалтыг хэрхэн бүртгэж тайлагнах талаар эрх зүйн тодорхой зохицуулалтгүй байна.

2.3.3. УУС-ын 2015 оны 49 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага” журмын 16.5³⁴-д тайлан материалыг гэрээлэгчээс Газрын тосны газрын мэдээллийн санд хүлээн авахаар заасан боловч бодит байдалд тус мэдээллийн санг архивын нэгж үүсгэх байдлаар ашиглаж байна. АМГТГ нь 2022-2023 онд “Газрын тосны талбайн нэгдсэн мэдээллийн цахим систем” /программ/-тэй болохоор төлөвлөн, холбогдох саналаа ЦХХХЯ-д хүргүүлсэн хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна.

2.3.4. Хайгуулын үйл ажиллагааны түр зогсолтын хугацаанд байгаль орчныг нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, орчны хяналт, судалгаа шинжилгээний ажлууд үргэлжлэх нөхцөлийг харгалзалгүйгээр АМГТГ-ын даргын 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн А/80 дугаар тушаалаар хайгуулын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргасан байх эрсдэлтэй байна.

³² Төрийн захиргааны байгууллага нь БХГ болон тухайн жилд төлөвлөсөн төлөвлөгөө, төсвийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын хэрэгжилтийн тайланг эрэл, хайгуул, ашиглалтын талбай тус бүрээр гарган дүгнэлтийн хамт Төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор хүргүүлж, танилцуулна

³³ Гэрээлэгч нь тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, гаргасан зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсний хэмжээг дараа оны нэгдүгээр улиралд багтаан холбогдох төрийн захиргааны төв болон ... байгууллагад хүргүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ

³⁴ Холбогдох мэргэжилтнүүд энэхүү журмын 16.4-т зааснаас бусад мэдээ, тайлан, анхдагч материалуудыг хянаж, гаргасан дүгнэлтийг үндэслэн тайлан материалыг гэрээлэгчээс Газрын тосны газрын мэдээллийн санд хүлээн авна

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аудитаар төрийн захиргааны байгууллагаас баталсан төлөвлөгөөг биелүүлээгүй, төсвийг хэтрүүлсэн, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, холбогдох хууль тогтоомжид нийцээгүй зэрэг зөрчилтэй 2,937,802.0 ам.долларыг гэрээлэгчдийн ӨНЗ-аас хасаж, нийт 15,971,308.7 ам.долларыг баталгаажууллаа.
2. Гэрээлэгчид хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг санхүүгийн тайландаа үнэн зөв, бүртгэж тайлагнаагүй, санхүүгийн анхан шатны баримтыг Монгол хэлээр үйлдээгүй зэрэг зөрчилтэй байна.
3. Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6, 36 дугаар зүйлийн 36.2, БХГ-ний холбогдох заалтыг зөрчин гэрээлэгч Жи Өү Эйч ХХК 1,100,421.9 ам.доллар, Капкорп Монголиа ХХК 192,404.9 ам.доллар, Петроматад ХХК 281,047.6 ам.долларын гүйлгээг гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн байна.
4. Тухайн жилийн хайгуулын ажлын болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан байгаль орчны холбогдох зардлын хэмжээ харилцан уялдаагүй, эдгээрийн хэрэгжилт хангалтгүй байна.
5. АМГТГ нь Газрын тосны тухай хуулийн 30, 31, 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс гэрээлэгчдээс төлөх нийт 4,799,703.2 ам.долларын төлбөрийн үлдэгдэлтэй байна.
6. АМГТГ цаг үеийн нөхцөл байдлыг бодитой үнэлээгүй, тооцоо судалгаанд үндэслэхгүйгээр Гэрээлэгчдийн 2019-2020 оны хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг баталсан байна.
7. АМГТГ-ын гүйцэтгэх хяналт шалгалтын ажил санхүүгийн 1-2 жилийн хоцролттой байгаагаас гэрээлэгчид ӨНЗ-ын болон санхүүгийн тайланд залруулга хийх, өртөг нөхөн тооцоход зөрүү гарах эрсдэлийг үүсгэж байна.
8. АМГТГ-аас Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх тогтсон стандарт, заавар, журам байхгүй, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй байна.
9. АМГТГ-аас гэрээлэгчдийн хайгуулын үйл ажиллагаанд байнгын хяналт тавих чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, хяналт хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн нэгдсэн бүртгэлгүй, хяналт тавих үйл ажиллагаа цахимжаагүй, архивын баримт эмх цэгцгүй, бүтцийн нэгжүүд ажлын уялдаагүй байна.
10. Аудитаар АМГТГ-т 4,799,703.2 ам.долларын төлбөрийг төсөвт төвлөрүүлэх акт тогтоож, зөрчил арилгуулах 4 албан шаардлага өгч, АМГТГ-ын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох 1 албан шаардлагыг УУХҮС-д хүргүүллээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллагуудын эрх бүхий албан тушаалтанд зөвлөж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. Төрийн холбогдох байгууллагаас гэрээлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгож, Засгийн газрын 2015 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага журам, 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмыг уялдуулан дараах асуудлуудыг тодорхой тусган, өөрчлөлт оруулах. Үүнд;
 - АМГТГ-аас гэрээлэгчдийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, чиглэл өгч байгаа өдөр тутмын ажлын тайлан, баримт материалд үндэслэн Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан хяналт шалгалтыг тухай бүр хэрэгжүүлж, тайлагнадаг байх чиг үүргийг нарийвчлан тусгах;
 - АМГТГ-аас гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, ӨНЗ зэрэгт хяналт шалгалт хийсэн тайланг ТАБ-д хүргүүлэх хугацааг гэрээлэгчийн санхүүгийн тайлан гаргах, залруулах хугацаатай уялдуулан тодорхойлох;
 - АМГТГ-аас гэрээлэгчийн хайгуулын үр дүнгийн жилийн эцсийн тайлан, мэдээ, БХГ болон тухайн жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын хэрэгжилтийн тайланг хүлээн авч үнэлэх, УУХҮЯ-д хүргүүлэх хугацааг тус тус цаглабартай болгон тогтоох.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:

1. Газрын тосны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг хэрэгжилтийг хангаж ажиллах;
2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага журмыг Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журамтай уялдуулан боловсруулж, батлуулах;
3. АМГТГ-ын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, хууль тогтоомжид заасан төлбөр урамшууллын төвлөрүүлэлт, гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавих чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах.

Ашигт малтмал, газрын тосны газрын даргад:

1. Гэрээлэгчдийн жилийн төлөвлөгөө, төсвийг батлахдаа цаг үеийн нөхцөл байдлыг бодитоор үнэлэн, тооцоо судалгаатай шийдвэр гаргах;
2. Гэрээлэгчдийн хайгуулын үйл ажиллагаа, хууль тогтоомжид заасан төлбөр урамшууллын төлөлт болон хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавих ажлыг үр нөлөөтэй зохион байгуулж хэрэгжүүлэх;

3. Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК-тай байгуулсан БХГ-ний 7.3.3 дахь заалтыг МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын 3.1.37-т нийцүүлж, эрх зүйн зөрчлийг арилгах;
4. ГТГ-ын даргын 2013 оны 28 дугаар тушаалаар баталсан Газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд мөрдөх жишиг үнийг зах зээлийн ханштай уялдуулж шинэчлэх;
5. Монголын алт (МАК) ХХК, Макс Ойл ХХК, Петроматад ХХК-уудын 2020 онд зарцуулсан зардлын гүйлгээг холбогдох хууль журамд нийцүүлэн тайлагнаж байх;
6. Гэрээлэгчдийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, чиглэл өгч байгаа өдөр тутмын ажлын тайлан, баримт материалдаа үндэслэн Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан хяналт шалгалтыг тухай бүр хэрэгжүүлж, тайлагнах ажлын зохион байгуулалтыг сайжруулах;
7. Гэрээлэгчдийн ӨНЗ-ын тайлан болон хяналт шалгалтын тайлангийн жишиг загварыг бий болгож, тайланг хүлээн авах, хүргүүлэх зэрэг асуудлыг журамлах;
8. Хайгуулын үйл ажиллагааны түр зогсолтын хугацаанд байгаль орчныг нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, орчны хяналт, судалгаа шинжилгээний ажлууд үргэлжлэх нөхцөлийг харгалзан, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй уялдуулж баталдаг байх;
9. "Газрын тосны талбайн нэгдсэн мэдээллийн цахим систем" /программ/-тэй болох асуудлыг шийдвэрлэж, үр дүнг хяналт шалгалт хийх, тайлан дүгнэлт гаргахад ашигладаг байх;
10. Байгууллагын үйл ажиллагааны дотоод хяналтыг сайжруулж, хууль тогтоомжид заасан төлбөр урамшууллын төвлөрүүлэлт, гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд тогтмол хяналт тавих чиг үүргийн хэрэгжүүлж ажиллах.

Хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдэд:

1. Энэхүү аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг 2019-2020 оны санхүүгийн тайлан болон ӨНЗ-ын тайландаа залруулж, баталгаажуулан, АМГТГ болон ҮАГ-т хүргүүлэх;
2. Газрын тосны тухай хууль, БХГ-д заасны дагуу хайгуулын үйл ажиллагаанд хамаарах зардлын гүйлгээг дотоодын арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэж, нягтлан бодох бүртгэлийг монгол хэл дээр хөтлөх зэрэг БХГ-ээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
3. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж, санхүүгийн тайлан болон ӨНЗ-ын тайланд нийт хөрөнгө оруулалт, зардлыг үнэн зөв бүртгэж тайлагнах;
4. Хайгуулын үйл ажиллагааны түр зогсолтын хугацаанд байгаль орчныг нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, орчны хяналт, судалгаа шинжилгээний ажлууд үргэлжлэх нөхцөлийг харгалзан, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулдаг байх.

**Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан
гэрээлэгчийн төсөв, гүйцэтгэл, ӨНЗ болон аудитаар баталгаажуулсан дүнгийн нэгтгэл**

/ам.доллар/

№	Гэрээлэгч компани	Талбайн нэр	2019-2020 он											
			Гэрээлэгчийн ирүүлсэн			АМГТГ-ын тооцооллоор					Аудитаар			
			Батлагдсан төсөв	Гүйцэтгэл /АМГТГ-т ирүүлсэн/	ӨНЗ-ын дүн тайлангаар ¹	Хассан дүн (-)	2020 он дамнасан (+)	ӨНЗ дүн	Захиргааны зардлын дүн ²	Нийт өртөг зардал	Аудитаар хасагдсан	ӨНЗ-ын дүн	Захиргааны зардлын дүн ²	Баталгаажсан нийт ӨНЗ
0	1	2	3	4	5	6	7	8=5-6+7	9=8*%	10=8+9	11	12=5-11	13=12*%	14=12+13
1	Капкорп Монголиа	Богд IV	1,425,191.0	820,410.0	675,755.3	207,555.0		468,200.3	23,410.0	491,610.3	222,976.6	452,778.7	22,638.9	475,417.6
2	ХХК	Онги V	1,465,487.0	853,270.0	771,452.6	211,091.0		560,361.6	28,018.1	588,379.7	236,896.8	534,555.8	26,727.8	561,283.6
3	Монголын алт /МАК/ ХХК	Төхөм Хурд	4,788,571.0	2,065,207.0	1,067,421.0	103.0	543,957.0	1,611,275.0	80,563.8	1,691,838.8	37.8	1,067,383.2	53,369.2	1,120,752.4
4	Макс Ойл ХХК	Арбулаг ХХИХ	1,430,315.0	62,100.0	60,506.0	11,372.0	2,365.0	51,499.0	2,575.0	54,074.0	21,527.5	38,978.5	1,948.9	40,927.4
5	Петроматад ХХК	Матад ХХ	15,365,713.0	13,825,911.0	12,942,945.4	1,181,510.0	244,322.0	12,005,757.4	224,399.3	12,236,186.0	1,181,528.3	11,761,417.1	224,403.5	11,985,820.6
6	Жи Өү Эйч ХХК /2019 он/	Номгон IX	1,959,731.0	1,011,594.0	1,392,686.8	670,711.0		721,975.8	36,098.8	758,074.5	696,015.7	696,671.0	34,833.6	731,504.6
2019 оны дүн			26,435,008.0	18,638,492.0	16,910,767.0	2,282,342.0	790,644.0	15,419,069.0	395,064.9	15,820,163.2	2,358,982.7	14,551,784.3	363,921.9	14,915,706.2
7	Жи Өү Эйч ХХК /2020 он/	Номгон IX	2,052,690.0	1,414,318.0	1,584,155.0	451,129.0		1,133,026.0	56,651.3	1,189,677.3	578,819.3	1,005,335.7	50,266.8	1,055,602.5
2020 оны дүн			2,052,690.0	1,414,318.0	1,584,155.0	451,129.0	-	1,133,026.0	56,651.3	1,189,677.3	578,819.3	1,005,335.7	50,266.8	1,055,602.5
Нийт дүн			28,487,698.0	20,052,810.0	18,494,922.0	2,733,471.0	790,644.0	16,552,095.0	451,716.2	17,009,840.5	2,937,802.0	15,557,120.0	414,188.7	15,971,308.7

Тайлбар: ¹Тайлангаарх дүнд нөхөгдөх захиргааны зардлын дүн ороогүй;

²Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д заасан "гэрээлэгчийн захиргааны зардал нь тухайн жилийн өртөг нөхөх зардлын тав хүртэл хувь байх".

**КАПКОРП МОНГОЛИА ХХК-ИЙН БОГД IV ТАЛБАЙН 2019 ОНЫ ХАЙГУУЛЫН
ЗАРДЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТАЙЛАН**

/ам.доллар/

№	Өртөг нөхөгдөх зардал	Тайлант жилийн зардал	Аудитаар хасагдсан зардал	2019 оны Баталгаажсан ӨНЗ
A	НӨХӨГДӨХ ЗАРДАЛ			
C.1	Капитал зардал			
C.1.1	Оффисийн тавилга эд хогшил	62.7	62.7	-
C.1.3	Тээврийн хэрэгсэл	19,169.7	6,498.8	12,670.9
C.1.4	Оффисийн тоног төхөөрөмж	3,573.7	1,574.0	1,999.7
C.1.5	Техникийн тоног төхөөрөмж	692.6		692.6
C.1.6	Биет бус хөрөнгө	13,143.5	13,143.5	0.0
	Дүн	36,642.3	21,279.0	15,363.2
A.1	Геологи, Геохими, Геофизикийн зардал			
A.1.1	Геологи	16,810.4	6,950.0	9,860.4
	Сейсмийн дахин боловсруулалт	16,853.2	4,500.0	12,353.2
A.1.4	Геофизик (Газрын)	17,152.3		17,152.3
A.1.6	Байр зүйн судалгаа	3,591.2	3,591.2	-
	Дүн	54,407.0	15,041.2	39,365.8
A.3	Өрөмдлөгийн зардал	-		
A.3.1	Өрөмдлөгийн бэлтгэл ажил (Өрөмийн зам талбай бэлдэх, кемп байгуулах, үйлдвэрлэлийн усны хангамж болон бусад зардал)	3,792.8	3,791.4	1.4
	Дүн	3,792.8	3,791.4	1.4
A.4	Үйл ажиллагааны зардал			
A.4.1	Цалингийн зардал	364,177.1	60,829.0	303,348.1
A.4.2	НДШ	53,042.3	8,799.3	44,243.0
A.4.3	Үйлчилгээний хөлс	43,648.2	39,975.35	3,672.8
A.4.4	Шуудан, харилцаа холбооны зардал	8,968.9	2,996.4	5,972.5
A.4.5.a	Томилолтын зардал (Дотоод)	2,414.3		2,414.3
A.4.5.b	Томилолтын зардал (Гадаад)	7,084.2	6,062.3	1,021.9
A.4.6	Даатгал	39,142.6	33,813.1	5,329.5
A.4.7	Материалын зардал	7,493.9	2,540.4	4,953.5
A.4.8	Түлш	2,925.1		2,925.1
A.4.9	Уур, ус, цахилгаан, дулааны зардал	1,920.7	651.1	1,269.6
A.4.10	Түрээс	45,191.6	25,857.8	19,333.8
A.4.11	Засвар үйлчилгээний хөлс	2,005.8	927.6	1,078.3
A.4.17	Тээврийн зардал	106.8	7.0	99.8
A.4.20	Бусад зардал	308.6	308.6	0.0
	Нийт үйл ажиллагааны зардал	580,913.2	182,865.0	398,048.2
	Нийт зардал /C1,A1, A3,A4/	675,755.3	222,976.6	452,778.7
	БХГ-ний дагуу нийт хайгуулын зардлын 5%	35,697.4	13,058.5	22,638.9
	ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ДҮН	711,452.7	236,035.1	475,417.6

Хавсралт 1-2

КАПКОРПМОНГОЛИА ХХК-НИЙ ОНГИ-V ТАЛБАЙН 2019 ОНЫ ХАЙГУУЛЫН
ЗАРДЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТАЙЛАН

/ам.доллар/

№	Өртөг нөхөгдөх зардал	Тайлант жилийн зардал	Аудитаар хасагдсан зардал	2019 оны баталгаажсан ӨНЗ
С.1	Капитал зардал			
С.1.1	Оффисийн тавилга эд хогшил	62.7	62.70	0.0
С.1.3	Тээврийн хэрэгсэл	19,169.7	19,169.69	-
С.1.4	Оффисийн тоног төхөөрөмж	3,573.7	2,592.41	981.3
С.1.5	Техникийн тоног төхөөрөмж	692.6	692.63	-
С.1.6	Биет бус хөрөнгө	13,143.5	13,143.53	(0.0)
	Дүн	36,642.2	35,660.96	981.3
А.1	Хайгуулын зардал	-		-
А.1.1	Геологи	22,578.0	6,542.90	16,035.1
А.1.2	Геохими	113,246.7	7,853.83	105,392.9
А.3	Өрөмдлөгийн бэлтгэл ажил	786.2	786.16	0.0
А.1.5	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ	11,588.7	11,386.00	202.7
	Нийт хайгуулын зардал	148,199.6	26,568.89	121,630.7
А.4	Үйл ажиллагааны зардал	-		-
А.4.1	Цалингийн зардал	372,079.5	62,819.46	309,260.1
А.4.2	НДШ	53,740.2	9,083.68	44,656.5
А.4.3	Үйлчилгээний хөлс	43,707.0	40,492.48	3,214.5
А.4.4	Шуудан, харилцаа холбооны зардал	8,839.5	2,996.42	5,843.0
А.4.5	Томилолтын зардал (Дотоод)	1,731.3	1,292.23	439.1
А.4.6	Томилолтын зардал (Гадаад)	7,278.5	5,061.53	2,217.0
А.4.7	Даатгал	39,142.6	33,296.14	5,846.5
А.4.8	Материалын зардал	7,493.9	2,540.47	4,953.4
А.4.9	Түлш	1,985.9	106.79	1,879.1
А.4.10	Ашиглалтын зардал	1,920.7	874.25	1,046.5
А.4.11	Засвар үйлчилгээний хөлс	2,005.8	373.09	1,632.7
А.4.12	Бичиг хэргийн зардал (Хэвлэл)	1,118.1		1,118.1
А.4.13	Олон нийттэй харилцааны зардал	27.6		27.6
А.4.14	Сургалтын зардал	1,002.4	554.29	448.1
А.4.15	Түрээсийн зардал	43,857.4	14,867.52	28,989.8
А.4.16	Зөвшөөрөл, хураамж	264.7		264.7
А.4.17	Бусад зардал/Тээвэр/	415.7	308.57	107.2
	Нийт үйл ажиллагааны зардал	586,610.8	174,666.91	411,943.9
	Нийт зардал /С1,А1, А3,А4/	771,452.6	236,896.8	534,555.9
	БХГ-ний дагуу нийт хайгуулын зардлын 5%	37,106.7	10,378.8	26,727.8
	Нийт ерөнхий удирдлагын зардал	37,106.7	10,378.8	26,727.8
	ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ДҮН	808,559.3	247,275.6	561,283.7

Хавсралт 1-3

**МОНГОЛЫН АЛТ /МАК/ ХХК-НИЙ ТӨХӨМ Х (урд) ТАЛБАЙН 2019 ОНЫ
ХАЙГУУЛЫН ЗАРДЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТАЙЛАН**

/ам.доллар/

№	Өртөг нөхөгдөх зардал	Тайлант жилийн зардал	Аудитаар хасагдсан зардал	2019 оны баталгаажсан ӨНЗ
A.1	Хайгуулын зардал	-		-
A.1.1	Геологи Геофизикийн судалгаа	-		-
A.1.2	Геологийн хээрийн маршрут, судалгаа	-		-
A.1.3	Геологийн загварчлал боловсруулах, мэдээллийн сан бүрдүүлэх	1,057,804.8		1,057,804.8
A.1.8	2 Хэмжээст чичирхийллийн судалгааны хяналт	4,371.7		4,371.7
	Нийт хайгуулын зардал	1,062,176.5	-	1,062,176.5
A.2	Үйл ажиллагааны зардал	-		-
A.2.1	Цалингийн зардал	802.8		802.8
A.2.2	НДШ-ийн зардал	- 365.5		- 365.5
A.2.3	Ажилчидтай холбоотой бусад зардал, сургалт	-		-
A.2.4	Түрээсийн зардал	-		-
A.2.5	Түрээсийн зардал Гадаад зөвлөх	-		-
A.2.6	Даатгалын зардал	-		-
	Геологи, Геохимийн зардал			
A.2.7	Цалингийн зардал	4,165.5		4,165.5
A.2.8	НДШ-ийн зардал	604.0		604.0
A.2.9	Тээврийн зардал	-		-
A.2.10	Зөвлөх үйлчилгээний зардал	-		-
A.2.11	Маркетинг болон орон нутгийн уулзалт зардал	-		-
A.2.12	Үйл ажиллагааны бусад зардал	37.8	37.8	-
A.2.13	Үндсэн хөрөнгө - талбай	-		
	Нийт үйл ажиллагааны зардал	5,244.7	37.8	5,206.9
	Нийт зардал /A1, A2/	1,067,421.2	37.8	1,067,383.4
A.3.1	БХГ-ний дагуу нийт хайгуулын зардлын 5%	53,371.1	1.9	53,369.2
	Нийт өртөг нөхөгдөх зардал /A1, A2, A3/	1,120,792.2	39.7	1,120,752.5

Хавсралт 1-4

МАКС ОЙЛ ХХК-НИЙ АРБУЛАГ ХХХ ТАЛБАЙН 2019 ОНЫ ХАЙГУУЛЫН ЗАРДЛЫН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН
ТАЙЛАН

/ам.доллар/

№	Өртөг нөхөгдөх зардал	Тайлант жилийн зардал	Аудитаар хасагдсан зардал	2019 оны баталгаажсан ӨНЗ
A.1	Хайгуулын зардал	-		-
	Байгаль орчны нөлөөлөлтийн нарийвчилсан үн	4,730.5	4,730.5	-
	Нийт хайгуулын зардал	4,730.5	4,730.5	-
A.2	Үйл ажиллагааны зардал	-		-
A.2.1	Цалингийн зардал	34,318.2	6,192.9	28,125.3
A.2.2	НДШ-ийн зардал	4,633.0	836.7	3,796.3
A.2.3	Ажилчидтай холбоотой бусад зардал	-		-
A.2.4	Түрээсийн зардал	-		-
A.2.5	Түрээсийн зардал Гадаад зөвлөх	-		-
A.2.6	Даатгалын зардал	-		-
A.2.7	Томилолтын зардал	3,943.9		3,943.9
A.2.8	Шатахуун, машины засвар үйлчилгээний зард	3,199.4	928.2	2,271.1
A.2.9	Олон нийттэй харилцааны зардал	44.2	44.2	0.0
A.2.10	Торгууль, алданги	9,636.5	8,795.0	841.5
A.2.11	Маркетинг болон орон нутгийн уулзалт зардал	-		-
A.2.12	Элэгдэл хорогдлын зардал Автомашин	-		-
	Нийт үйл ажиллагааны зардал	55,775.1	16,797.0	38,978.1
	Нийт зардал /A1, A2/	60,505.6	21,527.5	38,978.1
A.3.1	БХГ-ний дагуу нийт хайгуулын зардлын БХГ Г	5,807.1	3,858.2	1,948.9
	Нийт ерөнхий удирдлагын зардал	5,807.1	3,858.2	1,948.9
	Нийт өртөг нөхөгдөх зардал /A1, A2, A3/	66,312.8	25,385.7	40,927.1

Хавсралт 1-5

**"ПЕТРОМАТАД" ХХК-ИЙН МАТАД ХХ ТАЛБАЙН 2019 ОНЫ ХАЙГУУЛЫН
ЗАРДЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТАЙЛАН**

/ам.доллар/

№	Өртөг нөхөгдөх зардал	Тайлант жилийн зардал	Аудитаар хасагдсан зардал	2019 оны баталгаажсан ӨНЗ
A.1	Хайгуулын зардал	-		-
A.1.1	Геологи Геофизикийн судалгаа	53,860.0		53,860.0
A.1.8	2Д чичирхийлэлийн боловсруулалт	39,530.0	39,530.0	-
A.1.9	Өрөмдлөгийн бэлтгэл ажил (Өрөмийн зам талбай бэлдэх, кемп байгуулах, үйлдвэрлэлийн усны хангамж болон бусад зардал)	1,659,130.9		1,659,130.9
A.1.10	Өрөмдлөгийн үйл ажиллагаа	6,964,575.6	546,051.3	6,418,524.3
A.1.11	Өрөмдлөгийн ажлын тээврийн зардал (анги зохион байгуулах / татан буулгах)	583,259.0		583,259.0
A.1.12	Усан өрөмдлөг	62,231.8		62,231.8
A.1.13	Сул зогсолт болон кемпын засвар үйлчилгээ /үйл ажиллагаа/	165,000.0		165,000.0
A.1.14	Цооногийн туршилт	904,292.3		904,292.3
A.1.15	Цооногийн геофизикийн судалгаа / Каротаж/	159,500.0		159,500.0
A.1.16	Өрөмдлөгийн ажлын хяналт	487,340.8		487,340.8
A.1.18	Байгал орчны нөхөн сэргээх зардал	21,637.7		21,637.7
A.1.19	Байгаль орчны хяналт	46,845.6	8,141.5	38,704.2
	Нийт хайгуулын зардал	11,147,203.7	593,722.7	10,553,481.0
A.2.1	Цалингийн зардал	1,177,642.4	374,075.2	803,567.3
A.2.2	НДШ-ийн зардал	156,408.0	54,240.9	102,167.1
A.2.3	Үйлчилгээний хөлс	118,879.7	69,860.0	49,019.7
A.2.4	Шуудан, харилцаа холбооны зардал	2,368.9		2,368.9
A.2.5	Томилолтын зардал (Дотоод)	34,262.8	11,022.6	23,240.2
A.2.6	Томилолтын зардал (Гадаад)	10,093.6	2,094.0	7,999.7
A.2.7	Даатгал	163,590.3	63,590.3	100,000.0
A.2.8	Материалын зардал	18,281.6	436.6	17,845.0
A.2.9	Түлш	16,873.1	1,152.2	15,720.9
A.2.10	Түрээс	64,889.4	1,664.9	63,224.5
A.2.11	Засвар үйлчилгээний хөлс	172.5		172.5
A.2.12	Сургалтын зардал	103.9		103.9
A.2.13	Хэвлэл, захиалга	87.6		87.6
A.2.14	Тээврийн зардал	2,056.6		2,056.6
A.2.15	Зөвшөөрөл, хураамж	245.1	116.4	128.7
A.2.16	Бусад зардал	1,918.4	1,908.4	10.0
A.2.17	Олон нийттэй харилцааны зардал /орон нутаг/	11,776.1	7,048.3	4,727.8
A.2.19	Үндсэн хөрөнгө - талбай	16,091.6	596.0	15,495.6
	Нийт үйл ажиллагааны зардал	1,795,741.6	587,805.8	1,207,935.9
	Нийт зардал /A1, A2/	12,942,945.4	1,181,528.5	11,761,416.8
A.3.1	БХГ-ний дагуу нийт хайгуулын зардлын БХГ Г-2.3.11.2	227,356.7	2,953.2	224,403.5
	Нийт ерөнхий удирдлагын зардал	227,356.7	2,953.2	224,403.5
	Нийт өртөг нөхөгдөх зардал /A1, A2, A3/	13,170,302.1	1,184,481.7	11,985,820.4

Хавсралт 1-6

**ЖИ ӨҮ ЭЙЧ ХХК-НИЙ НОМГОН IX ТАЛБАЙН 2019 ОНЫ ХАЙГУУЛЫН ЗАРДЛЫН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ-ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН
ТАЙЛАН**

/ам.доллар/

№	Өртөг нөхөгдөх зардал	Тайлант жилийн зардал	Аудитаар хасагдсан зардал	2019 оны баталгаажсан ӨНЗ
A.1	Хайгуулын зардал	-		-
A.1.1	Геологи Геофизикийн судалгаа	112,160.5	112,160.5	-
A.1.2	Геологийн хээрийн маршрут, судалгаа	31,923.9	31,923.9	-
A.1.3	Геологийн загварчлал боловсруулах, мэдээллийн сан бүрдүүлэх	54,933.1	54,933.1	-
A.1.4	Нөхөн сэргээлтийн зардал	-		-
A.1.5	2 Хэмжээст чичирхийллийн судалгаа	334,577.6		334,577.6
A.1.6	2 Хэмжээст чичирхийллийн судалгааны боловсруулалт	-		-
A.1.7	2 Хэмжээст чичирхийллийн судалгааны тайлан	12,600.0	12,600.0	-
A.1.8	2 Хэмжээст чичирхийллийн судалгааны зөвлөх	31,227.3	10,227.3	21,000.0
A.1.9	Өрөмдлөгийн зардал	-		-
	Цооногийн төлөвлөлт	33,628.2	33,628.2	-
	Хайгуулын цооног өрөмдөх	468,219.0	228,256.1	239,962.9
	Цооногийн даатгал	-		-
	Зөвлөх үйлчилгээ, хяналт	73,760.7	73,760.7	-
A.1.10	Байгаль орчин тайлан			-
	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ	19,187.0		19,187.0
	Байгаль орчны нөлөөлөлтийн нарийвчилсан үнэлгээ	41,621.2	6,621.2	35,000.0
	Археологи угсаатны зүйн судалгаа	-		-
	Палентологийн судалгаа	-		-
	Байгаль орчны баталгаа	5,820.7	5,820.7	-
	Нийт хайгуулын зардал	1,219,659.2	569,931.8	649,727.4
A.2	Үйл ажиллагааны зардал	120,000.0	120,000.0	-
A.2.7	Томилолтын зардал	7,891.7	5,336.4	2,555.3
A.2.8	Шатахуун, машины засвар үйлчилгээний зардал	3,252.5	747.6	2,505.0
A.2.13	Үндсэн хөрөнгө - талбай	41,883.3		41,883.3
	Нийт үйл ажиллагааны зардал	173,027.6	126,084.0	46,943.6
	Нийт зардал /A1, A2/	1,392,686.8	696,015.7	696,671.0
A.3	Ерөнхий удирдлагын зардал	-		-
A.3.1	БХГ-ний дагуу нийт хайгуулын зардлын 5%	69,634.3	34,800.8	34,833.6
	Нийт ерөнхий удирдлагын зардал	69,634.3	34,800.8	34,833.6
	Нийт өртөг нөхөгдөх зардал /A1, A2, A3/	1,462,321.1	730,816.5	731,504.6

Хавсралт 1-7

ЖИ ӨҮ ЭЙЧ ХХК-НИЙ НОМГОН IX ТАЛБАЙН 2020 ОНЫ ХАЙГУУЛЫН ЗАРДЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ-ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТАЙЛАН

/ам.доллар/

№	Өртөг нөхөгдөх зардал	Тайлант жилийн зардал	Аудитаар хасагдсан зардал	2020 оны баталгаажсан ӨНЗ
A.1	Хайгуулын зардал	-		-
A.1.1	Геологи Геофизикийн судалгаа	152,473.42	135,835.6	16,637.8
A.1.3	Геологийн загварчлал боловсруулах, мэдээллийн сан бүрдүүлэх	62,222.81	51,324.0	10,898.8
A.1.4	Нөхөн сэргээлтийн зардал	-		-
A.1.5	2 Хэмжээст чичирхийллийн судалгаа	272,383.16		272,383.2
A.1.7	2 Хэмжээст чичирхийллийн судалгааны тайлан	12,586.50	12,586.5	-
A.1.8	2 Хэмжээст чичирхийллийн судалгааны зөвлөх	8,447.88		8,447.9
A.1.9	Өрөмдлөгийн зардал	-		-
	Стратиграфийн цооног	193,603.47		193,603.5
	Хайгуулын чөмөг дээжлэлтэй цооног	577,499.21	127,499.2	450,000.0
	Давхаргын даралт хэмжилт (IFOT)	53,975.00	53,975.0	-
	Зөвлөх үйлчилгээ, хяналт	22,032.00	22,032.0	-
	Геологийн болон өрөмдлөгийн хяналт	68,427.43	37,406.3	31,021.2
A.1.10	Байгаль орчин тайлан	-		-
	Байгаль орчны хяналт	7,117.04	4,816.2	2,300.9
	Байгаль орчин хамгаалах ажил, менежмент	22,359.17	8,627.7	13,731.5
	Байгаль орчны баталгаа	-		-
	Нийт хайгуулын зардал	1,453,127.10	454,102.5	999,024.6
A.2	Үйл ажиллагааны зардал	120,000.00	120,000.0	-
A.2.1	Цалингийн зардал	1,785.11		1,785.1
A.2.2	НДШ-ийн зардал	72.86		72.9
A.2.7	Томилолтын зардал	8,566.74	4,540.8	4,026.0
A.2.8	Шатахуун, машины засвар үйлчилгээний зардал	-	176.0	- 176.0
A.2.13	Үндсэн хөрөнгө - талбай	603.46		603.5
	Нийт үйл ажиллагааны зардал	131,028.17	124,716.8	6,311.4
	Нийт зардал /A1, A2/	1,584,155.27	578,819.3	1,005,336.0
A.3	Ерөнхий удирдлагын зардал	-		
A.3.1	БХГ-ний дагуу нийт хайгуулын зардлын 5%	69,083.05	18,816.2	50,266.8
	Нийт ерөнхий удирдлагын зардал	69,083.05	18,816.2	50,266.8
	Нийт өртөг нөхөгдөх зардал /A1, A2, A3/	1,653,238.32	597,635.5	1,055,602.8

Хавсралт 1-8

**ШУНХЛАЙ ЭНЕРЖИ ХХК-НИЙ СУЛИНХЭЭР ХХИИ ТАЛБАЙН 2015 ОНЫ
ХАЙГУУЛЫН ЗАРДЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ-ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТАЙЛАН**

/ам.доллар/

№	Өртөг нөхөгдөх зардал	Тайлант жилийн зардал	Аудитаар хасагдсан зардал	2019 оны баталгаажсан ӨНЗ
A	НӨХӨГДӨХ ЗАРДАЛ	-		-
A.1.1	2 Хэмжээст чичирхийллийн судалгаа болон үр дүнгийн тайлал боловсруулалтын зардал	594,010.0		594,010.0
A.1.2	2 Хэмжээст чичирхийллийн судалгаа болон үр дүнгийн тайлал боловсруулалт	96,000.0		96,000.0
A.1.3	Хээрийн анги, тоног төхөөрөмжийн нүүлгэлт	-		-
A.1.4	Хяналтын инженерийн зардал	48,868.2	3,329.1	45,539.2
A.1.5	бусад зардал	5,074.9	250.9	4,824.1
A.1.6	2 Хэмжээст чичирхийллийн судалгаа болон үр дүнгийн тайлал боловсруулалт	-		-
A.1.7	Цооногийн босоо чичирхийллийн судалгаа /VSPSS@ VSPQL	-		-
A.1.8	VSP-ийн нүүлгэлт	-		-
	Нийт хайгуулын зардал	743,953.2	3,579.9	740,373.3
A.3.1	БХГ-ний дагуу нийт хайгуулын зардлын 5%	37,197.7	179.0	37,018.7
	Нийт ерөнхий удирдлагын зардал	37,197.7	179.0	37,018.7
	Нийт өртөг нөхөгдөх зардал	781,150.8	3,758.9	777,391.9

Холбогдох байгууллагын санал:

1. Капкорп Монголиа ХХК-ийн ирүүлсэн санал:



“Капкорп Монголиа” ХХК
УБД 9019014069

“ ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР ”

2023.01.06 № 003/023
танай -ны -т

“ БХГ-т Богд-IV болон Онги-V
талбайн ӨНЗ-ын урьдчилсан
дүгнэлтийн хариу хүргүүлэх тухай ”

Газрын тосны салбарт Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-т “Богд-IV” болон “Онги-V” талбайн 2019 оны өртөг нөхөгдөх зардал (ӨНЗ)-ын тайланг хянан шалгаж, урьдчилсан дүгнэлт гаргасан тайлантай танилцаад дараах хариу тайлбарыг хүргүүлж байна. Тус тайлангаар “Богд-IV” талбайн ӨНЗ-с 267,347.50 ам.доллар, “Онги-V” талбайн ӨНЗ-с 351,481.09 ам.долларын гүйлгээг тус тус нөхөгдөх зардлаас хасахаар урьдчилсан дүгнэлт гаргасан байгаагаас “Богд-IV” талбайн ӨНЗ-с 37,569.94 ам.доллар, “Онги-V” талбайн ӨНЗ-с 37,257.12 ам.долларын зардлуудыг ӨНЗ-аас хасахыг хүлээн зөвшөөрч, “Богд-IV” талбайн ӨНЗ-с 229,777.56 ам.доллар, “Онги-V” талбайн ӨНЗ-с 314,223.97 ам.долларын зардлуудыг ӨНЗ-аас хасахыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул дэлгэрэнгүй тайлбарын хавсралт, санхүүгийн баримтын хуулбарууд илгээлээ, хүлээн авна уу.

Хавсралт:

1. “Богд-IV” талбайн “Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт”-нд дэлгэрэнгүй тайлбарын тусгасан байдлаар - /2 хуудас/
2. “Богд-IV” талбайн 2019 оны өртөг нөхөгдөх зардлаас хасагдах үндэслэлгүй гэж үзсэн зардлуудын жагсаалт - /2 хуудас/
3. “Онги-V” талбайн “Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт”-нд дэлгэрэнгүй тайлбарын тусгасан байдлаар - /3 хуудас/
4. “Онги-V” талбайн 2019 оны өртөг нөхөгдөх зардлаас хасагдах үндэслэлгүй гэж үзсэн зардлуудын жагсаалт - /5 хуудас/
5. Байгаль орчны хэлтсийн тайлбар - /15 хуудас/
6. Байгаль орчны хэлтсийн тайлбарын хавсралт материалууд - /1 диск/
7. Анхан шатны баримтууд - /10 хуудас/

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал

КАПКОРП
МОНГОЛИА
ХХК

А. Гэрэлт-Од

Капкорп Монголиа ХХК-ийн ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Санал	Хариу тайлбар
Богд IV талбай	
Санхүүгийн шинжээчтэй холбоотой	Ирүүлсэн тайлбарын хүрээнд нэмэлтээр гаргаж ирүүлсэн нотлох баримтыг дахин үнэлж 16,763.0 ам.долларын зардлыг хүлээн зөвшөөрч, бусад зардлын дүнг хүлээн зөвшөөрч өөрчлөх үндэслэлгүй гэж дүгнэсэн.
Байгаль орчны шинжээчтэй холбоотой	Аудитын хамрах хугацаа буюу 2019-2020 онд байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд ирүүлсэн санал нь 2018 оных байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
Онги V талбай	
Санхүүгийн шинжээчтэй холбоотой	Ирүүлсэн тайлбарын хүрээнд нэмэлтээр гаргаж ирүүлсэн нотлох баримтыг дахин үнэлж 87,468.2 ам.долларын зардлыг хүлээн зөвшөөрч, бусад зардлын дүнг хүлээн зөвшөөрч өөрчлөх үндэслэлгүй гэж дүгнэсэн.
Байгаль орчны шинжээчтэй холбоотой	Аудитын хамрах хугацаа буюу 2019-2020 онд байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд ирүүлсэн санал нь 2018 оных байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.

2. Монголын алт /МАК/ ХХК-ийн ирүүлсэн санал:



“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК

Хан-Уул дүүрэг 1-р хороо, 19-р хороолол,
Чингисийн өргөн чөлөө, “Монголын Алт” (МАК)
ХХК-ийн төв байр-44, Улаанбаатар хот 17030, Ш/х-66
Утас: +976-70107482, 75759700; Факс: +976-70107481
Эл.шуудан: mak@mak.mn

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАРТ**

2023.01.06 № 02/14

танай _____ - ны (ний) № _____-т

Бүтээгдэхүүн хуваах гэрээнд өөрчлөлт оруулах санал болон тайлбар хүргүүлэх тухай

Үндэсний Аудитын газрын 2022.12.27-ны өдрийн 01/2058 тоот албан бичгийг хүлээн авч холбогдох дүгнэлттэй танилцлаа.

Манай компаниас хавсралтаар - “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-нд өөрчлөлт оруулах санал болон тайлбарыг хүргүүлж байна. Бидний хүсэлтийг хүлээн авна уу.

ГЕОЛОГИ, ХАЙГУУЛ ЭРХЭЛСЭН
ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ





Ч.МИЖИДДОРЖ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР-аас ирүүлсэн дүгнэлттэй
холбогдуулан тайлбар гаргах тухай

1. Газрын тосны хайгуулын “Төхөм-Х урд” талбайд 1120 тууш.км Хоёр хэмжээст чичирхийллийн судалгааны ажил гүйцэтгэх 257-1019 тоот гэрээг “ЭрдСан петролиум” ХХК-тай 2019 оны 5 дугаар сард байгуулсан.

Судалгааны ажил 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Дорноговь аймгийн Мандах сумын нутагт эхэлсэн бөгөөд Covid-19 вирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, хөл хорионы дэглэм тогтоосны улмаас судалгааны ажлыг **625,9** тууш.км буюу **55,9 %** хувийн гүйцэтгэлтэйгээр 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрөөс тодорхойгүй хугацаагаар зогсоосон болно.

Ковид-19 цар тахлын улмаас 257-1019 тоот гэрээнд тусгасан ажлыг бүрэн гүйцэтгэх боломжгүй болж, ажлын хэмжээ **625,9** тууш.км болж багассан тул 257-1019 тоот гэрээнд өөрчлөлт оруулахаар талууд харилцан тохиролцож 2020 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 2 хэмжээст чичирхийллийн судалгааны гүйцэтгэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, талууд баталгаажуулсан.

2020 онд зарцуулсан нийт 552,692.64 ам.долларын зардал нь 2019 оны 257-1019 тоот үндсэн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан болон тухайн гэрээт ажилтай холбоотой тооцоо тул 552,692.64 ам.долларын зардлыг өртөг нөхөгдөх зардалд оруулах.

2. 2019 онд “Төхөм-Х урд” талбайд 1120 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг АМГТГ-аар хянуулж батлуулсан бөгөөд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу “Төхөм-Х урд” талбайн 2019 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулсан.

Ковид-19 цар тахлын улмаас судалгааны ажил 2020 оны 2 дугаар сарын 21-ны өдрөөс тодорхойгүй хугацаагаар зогссон бөгөөд 2020 оны 5 дугаар сарын 5-ны өдөр хайгуулын түр кэмийг татан буулгаж, сум, орон нутгийн ЗДТГ, Байгаль орчны хяналтын улсын байцаагчид кемпийн газар болон судалгааны талбайн нөхөн сэргээлтийг газар дээр нь танилцуулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А50/А31 тоот хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтын дагуу нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авсан тухай акт үйлдэж тайландаа хавсаргасан.

Мөн БОАЖЯ-аар 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 4 дүгээр хавсралтын дагуу “Төхөм-Х урд” талбайн 2019 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг **91.1%** хувьтай дүгнүүлж БОАЖЯ-аар хянуулж баталгаажуулсан.

3. “Төхөм-Х урд” талбайн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээг тогтоох, түүнийг багасгах, арилгах, цаашид авах арга хэмжээний оновчтой хувилбарыг тогтоох зорилгоор *“Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын ажил”*-ыг “Хатан далай” ХХК-иар гүйцэтгүүлэхээр 2019 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр гэрээ байгуулсан. Энэхүү ажлыг “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-д нийцүүлэн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 4

дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу чанартай, мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн бөгөөд БОННУ-ний нэмэлт тодотголын ажлын тайлангийн эх хувийг АМГТГ болон БОАЖЯ-нд хүлээлгэн өгсөн.


4. 2019 онд “Төхөм-Х урд” талбайд 1120 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулсан боловч Ковид цар тахлын улмаас 625,9 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.
- 2019 оны хайгуулын ажлын төлөвлөгөөнд Газрын тосны өрөмдлөгийн ажил тусгагдаагүй тул өрөмдлөгийн ажил хийгдээгүй болно.

“Төхөм-Х урд” талбайн 2019 оны хайгуул судалгааны ажлыг батлагдсан хайгуулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан бөгөөд гүйцэтгэлтэй холбоотой гэрээ, ажлын гүйцэтгэлийн баримт материал, акт, тайлан бүгд байгаа болно. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй тул тухайн ажил БОМТ болон хэрэгжилтийн тайланд байхгүй.

Иймд Үндэсний Аудитын газрын 2022.12.27-ны өдрийн 01/2058 тоот албан бичгийн хавсралт болох *Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягтын* 5, 6-д заасан тайлбартай санал нийлэхгүй байгаагаа үүгээр илэрхийлж байна.

Тайлбар бичсэн:

Газрын тосны мэргэжилтэн

 Н.Ганхүлэг

2023.01.05

Монголын алт /МАК/ ХХК-ийн ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Санал	Хариу тайлбар
Санал 1	Тайлангийн 2.2.3-т тусгасны дагуу саналыг хүлээн авах боломжгүй.
Санал 2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тайлан, мониторингийн мэдээлэл зэргийг нэмж ирүүлээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.
Санал 3	Санал авсан тайлан, асуудлын бүртгэлд тусгаагүй асуудал байна.
Санал 4	Өрөмдлөгийн ажил хийгээгүй ч Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна гэж заасныг хэрэгжүүлээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.

3. МАКС ОЙЛ ХХК-ийн ирүүлсэн санал:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МАКС ОЙЛ ХХК

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

5-р хороо, Самбуугийн гудамж, М плаза,

16 давхар 1604 тоот, Утас: 976-77772525

Электрон шуудан: maxmining@maxgroup.mn

2023.01.06 № А-24-28/01.

танай 2022.12.27 -ны № 01/2058.

Хариу хүргүүлэх тухай

Танайхаас ирүүлсэн 12 сарын 27-ны өдрийн 01/2058 тоот албан бичигтэй танилцлаа. Манай компани тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан журмын дагуу 2019 оны Өртөг нөхөгдөх зардлын тайлангаа тайлагнасан. Иймд 2019 онд Өндөрхаан трейд ХХК руу шилжүүлсэн нийт 6,250,000 (зургаан сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг он дамнасан гэх үндэслэлээр хасах шаардлагагүй гэж үзэж байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын тосны бүртгэл, тооцооны журам"-д заасны дагуу манай доорх 2 зардлыг 2019 оны Өртөг нөхөгдөх зардлын тайланд оруулах хүсэлтэй байна.

№	Харилцагч байгууллага	Зардлын хэмжээ
1	Терра Эксплорерс Лимитед Монголиа ХХК	50,000,000 (тавин сая) төгрөг
2	Шинжиан Жэнтун Монголиа Тэхнологи Үйлчилгээ ХХК	185,500,000 (нэг зуун наян таван сая таван зуун мянга) төгрөг

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

МАКС ОЙЛ ХХК-ийн ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Санал	Хариу тайлбар
Санал 1	Тайлангийн 2.2.3-т тусгасны дагуу саналыг хүлээн авах боломжгүй.
Санал 2	Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 болон Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 11.2-т заасны дагуу хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардал зэрэгт АМГТГ-аас хяналт, шалгалт хийж, гаргасан дүгнэлт, тайланг УАГ-т ирүүлэх зохицуулалттай тул саналыг хүлээн авах боломжгүй.

4. Петроматад ХХК-ийн ирүүлсэн санал:



PETROMATAD

“Петро Матад” ХХК
УБД 9019017097

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2023.01.06 № 003/023
танай _____ -ны _____ -т

БХГ-т Матад-ХХ талбайн ӨНЗ-ын урьдчилсан дүгнэлтийн хариу хүргүүлэх тухай

Газрын тосны салбарт Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-т “Матад-ХХ” талбайн 2019 оны өртөг нөхөгдөх зардал (ӨНЗ)-ыг хянан шалгаж, урьдчилсан дүгнэлт гаргасан тайлантай танилцаад дараах хариу тайлбарыг хүргүүлж байна. Тус тайлангаар нийт 1,477,714.21 ам.долларын гүйлгээг нөхөгдөх зардлаас хасахаар урьдчилсан дүгнэлт гаргасан байгаагаас 407,264.67 ам.долларын зардлуудыг ӨНЗ-аас хасахыг хүлээн зөвшөөрч, 1,070,449.54 ам.долларын зардлуудыг ӨНЗ-аас хасахыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул дэлгэрэнгүй тайлбарын хавсралт, санхүүгийн баримтын хуулбарууд илгээлээ, хүлээн авна уу.

Хавсралт:

1. “Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт”-нд дэлгэрэнгүй тайлбарын тусгасан байдлаар - /3 хуудас/
2. Матад ХХ талбайн 2019 оны өртөг нөхөгдөх зардлаас хасагдах үндэслэлгүй гэж үзсэн зардлуудын жагсаалт - /6 хуудас/
3. Байгаль орчны хэлтсийн тайлбар - /21 хуудас/
4. Байгаль орчны хэлтсийн тайлбарын хавсралт материалууд - /1 диск/
5. Анхан шатны баримтууд - /120 хуудас/

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал



А. Гэрэлт-Од

Петроматад ХХК-ийн ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Санал	Хариу тайлбар
Санхүүгийн шинжээчтэй холбоотой	Ирүүлсэн тайлбарын хүрээнд нэмэлтээр гаргаж ирүүлсэн нотлох баримтыг дахин үнэлж 289,548.3 ам.долларын зардлыг хүлээн зөвшөөрч, бусад зардлын дүнг хүлээн зөвшөөрч өөрчлөх үндэслэлгүй гэж дүгнэсэн.
Байгаль орчны шинжээчтэй холбоотой	“СЭС” ХХК хийсэн ажлын тайлангаа нөхөж ирүүлсэн тул саналыг хүлээн авлаа.
	Тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөөнд тусгаснаас 1 дүгээр цооног орчмын хог, хаягдал бохир ус зайлуулахад 27,225.0 ам.доллар /хар саарал ус/, 3 дугаар цооног бөглөхөд 100,000.0 ам.доллар зарцуулж, өрөмдлөгийн ажлын хэсэг, гэрээт байгууллага гүйцэтгэсэн.Үүнийг байгаль хамгаалах төлөвлөгөө рүү тусгаж оруулбал тухайн жилийн БОМТ-ний барьцаа хөрөнгө их гарна, төрийн байгууллага нь буцааж өгдөггүй, хайгуулын ажилтай уялдуулна гэснээс төсөвтэй уялдуулна гэж заагаагүй гэжээ. Хог хаягдал, бохир ус зайлуулах, цооног бөглөх нөхөн сэргээх зэрэг нь төслийн явцад байгаль орчныг хамгаалах ажлын гол хэсэг бөгөөд гэрээт байгууллагад төлбөр төлөөд энэ ажлыг гүйцэтгүүлэх нь тухайн байгууллагын шийдэх асуудал ч байгаль орчныг хамгаалах ажлыг байгаль хамгаалах хэсэгт хамруулж, зардлыг бодитоор тооцон тусгаж, байгаль орчны мэргэжилтэн нар гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээллийг хүлээж авах үүрэгтэй тул саналыг хүлээн авах боломжгүй.
	БОМТ-ний тайланд Цэцүүх трейд ХХК-аар аюултай хог хаягдал устгах гэрээ хийж гүйцэтгүүлснээр тайлагнасан нь гэрээний дагуу хийсэн ажил, холбогдох баримт нотолгоо тайланд тусгагдаагүй, аюултай хог хаягдлыг хэрхэн устгасан талаар нэмэлт материал ирүүлээгүй тул тайлбарыг хүлээн авах боломжгүй болно.
	Дүйцүүлэн хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагын боловсруулсан БОННҮТ болон БОМТ-д тусгаагүй учир хийгээгүй гэж тайлбар ирүүлсэн ч Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж өрмийн шингэн хаягдлын санг /химийн найрлага бүхий/ 2 тн химийн нэмэлт бодисоор талсжуулан, хучилт хийн булаад орхиж байгаа талаар тайландаа тусгажээ. Иймд хаягдлын сан алга болохгүй, тэр булсан газар нөхөн сэргээгдэхгүй, дахин өөр зориулалтаар ашиглаж боломжгүй, энэ процессоос байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болох ус, хөрс зэрэгт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй гэх баталгаа байхгүй байхад дүйцүүлэн хамгаалах ажил хийх шаардлага байхгүй гэсэн тайлбарыг хүлээн авах боломжгүй.

5. Жи Өү Эйч ХХК-ийн ирүүлсэн санал:



“Жи Өү Эйч” ХХК

Монгол улс, Улаанбаатар хот-
14240, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр
хороо, Чингисийн өргөн чөлөө-15,
Гэндэнгийн гудамж, Гэндэнгийн
гудамж, Централ Парк барилга, 13
давхар, 13В тоот
у: +976-77552011
в: www.elixirenergy.net.au

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

2023.01.05

Дугаар: 1/07

Өртөг нөхөгдөх зардлын баталгаажуулалттай
холбоотой санал хүргүүлэх тухай

Номгон IX талбайд Нүүрсний давхаргын метан хийн хайгуул ашиглалтын үйл ажиллагаа эрхлэхээр Ашигт малтмал, газрын тосны газартай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан ажиллаж буй манай компани 2019-2020 оны өртөг нөхөгдөх зардлын баталгаажуулалтын талаарх аудитын дүгнэлтэд доорх саналыг хүргүүлж байна.

Тус дүгнэлтээр “Бүтээгдэхүүн хуваах гэрээний 14.1.1 дүгээрт “Гэрээлэгч эсхүл оператор компани нь газрын тосны хайгуул, ашиглалт, бүтээн байгуулалт, татан буулгалтын үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль тогтоомж болон гэрээний дагуу монгол хэл дээр, шаардлагатай гэж үзвэл Монгол, Англи хэл дээр давхар хөтөлнө” гэснийг мөрдөөгүй” гэж, “зөрчлийг зөрчлийн тухай хуулийн 9.10 дугаар зүйлийн 9.10.3 дахь хэсэг, 11.18 дугаар зүйлийн 11.18.1.2 дахь заалтын дагуу хариуцлага тооцох эрх бүхий байгууллагад шилжүүлэх” гэсэн; Мөн “Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.2.6 дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний 14.1.2 дугаарх заалтад холбогдох зөрчлийг зөрчлийн тухай хуулийн 7.13 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага тооцох эрх бүхий байгууллагад шилжүүлэх, Зөрчлийг арилгах” гэсэн дүгнэлтийн төслийн 2 заалтад Манай компани “2019 болон 2020 оны аудитыг нэгтгэн хийхэд нэг зөрчил илэрсэн” гэж үзэж байгаа тул зөрчлүүдийг он тус бүрээр тооцуулахгүй байх буюу нэгтгэж тооцуулах саналтай байна.

2020 оны аудитын дүгнэлтийн төслөөс өрөмдлөгийн үйл ажиллагааны зардалд төлсөн дотоодын компани болох “Эрдэнэдрилин” ХХК-ийн #20/03/005 дугаар нэхэмжлэх 66,111.65 /жаран зургаан мянга нэг зуун арван нэг зууны жаран

тав/-н доллар болон 20/02/008 дугаар нэхэмжлэхийн 60,566.48 /жаран мянга таван зуун жаран зургаа зууны дөчин найм/-н долларыг Бүтээгдэхүүн хуваах гэрээний "Г" хавсралтын 2.4.2 болон Газрын тосны бүртгэл тооцооны журмын 3.1.3 дахь үндэслэлээр төсвөөс хэтэрсэн ангилалд оруулж хасч тооцсон ба манай зүгээс Хайгуулын ажлын батлагдсан төсвөөр Өрөмдлөгийн зардал ангилалд нийт 865,000.00 /найман зуун жаран таван мянга/-н долларыг төсөвлөсөн ба өрөмдлөгийн төсөвт орсон цооног өрөмдөх зардал болон давхаргын даралт хэмжилтийн ажлын төсөв нийт цооног өрөмдөх ажилтай салшгүй уялдаатай ба төсөвтөө задалж харуулсан. Тус давхаргын даралт хэмжилт ангилал дээр байгаа зардалыг Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.2.6 дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.2 хэсэг болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний 14.1.2 дугаар заалтуудыг зөрчсөн гэж хассан байгаа тул "Эрдэнэдриллинг" ХХК-ас хассан дээрх зардлын дүнгээс давхаргын туршилт хэмжилт дээр тавигдсан төсөв 20,000.00 /хорин мянга/-н долларыг хасч тооцуулах саналтай байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



НИЙЛ ЁНГ

Жи Өү Эйч ХХК-ийн ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Санал	Хариу тайлбар
Санал 1	АМГТГ-т албан шаардлага хүргүүлэхээр болсон.
Санал 2	БХГ-ний 7.3-т Хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв батлуулах, түүний гүйцэтгэл, 7.3.1-т ...гэрээт жилд гүйцэтгэх хайгуулын ажлын нэр төрөл бүрээр нарийвчлан боловсруулж, ... гэж заасан тул саналыг хүлээн авах боломжгүй.

6. Шунхлай энерги ХХК-ийн ирүүлсэн санал:



“ШУНХЛАЙ ЭНЕРГИ” ХХК

Монгол улс, Сүхбаатар дүүрэг 1-р хороо,
Чингисийн өргөн чөлөө, Гранд Оффис, 6-65 тоот
Шуудангийн хайрцаг: Төв шуудан № 699
Утас: 77119007; Вэб хуудас: www.shunkhlai-energy.mn

2023-01-02 № 01
2022.12.27 № 01/2063 Т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР-Т

Санал х үргүүлэх тухай

Танай 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 01/2063 тоот албан бичигтэй танилцлаа. Манай компанийн Сулин хээр ХХИИ газрын тосны хайгуулын талбайд 2015 онд хийгдсэн ажлын өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулахтай холбоотой асуудлаар компанийн зүгээс ямар нэгэн санал байхгүй болно.

ХҮНДЭТГЭСЭН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



Б. ТЭМҮҮЛЭН

7. АМГТГ-аас ирүүлсэн санал:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**
Засгийн газрын XII байрны баруун жигүүр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70,
Цахим шуудан: info@mrpam.gov.mn,
Цахим хуудас: mrpam.gov.mn

2023. 01. 31 № 1/ 655
танай 2023. 01. 19-ны № 01/105-Т

Хариу хүргүүлэх тухай

Танай газраас 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/105 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит"-ын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д заасны дагуу аудитын тайлангийн төсөлд өгөх саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 4-ыг хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Л.БАЯРМАНДАЛ



5374 01002

Ашигт малтмал, газрын тосны газрын
20.43 оны 0.1 дугаар сарын 31-ний өдрийн
1/635 тоот албан бичгийн хавсралт

Аудитын тайлангийн төсөл дэх дүгнэлтэд өгөх тайлбар, санал

Дүгнэлтийн 1-д:

Аудитын тайлангийн төсөлд гэрээлэгчдийн ӨНЗ-аас хассан 2,937,802.0 ам.долларын дэлгэрэнгүй задаргаа байхгүй тул Дүгнэлт 1-д санал өгөх боломжгүй байна.

Дүгнэлтийн 2-т:

Гэрээлэгчдийн зүгээс санхүүгийн баримт бүрийг орчуулах нь компанийн зардлыг нэмэгдүүлнэ гэсэн тайлбарыг тавьдаг хэдий ч АМГТГ нь санхүүгийн анхан шатны баримтыг Монгол хэлээр үйлдэх шаардлагыг байнга тавьдаг.

Дүгнэлтийн 4-т:

Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулагдмагц гэрээний хавсралтад заасан хайгуулын ажлын доод хэмжээ, түүнээс үүсэх нөлөөллийг үнэлэх зорилгоор Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-т заасны дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэж, БОАЖЯ-нд хянуулж, батлуулдаг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасны дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд байгаль орчны менежментийн төлөвлөгөө тусгагдсан байдаг.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу тухайн жилийн хайгуулын үйл ажиллагаа эхлэхээс өмнө боловсруулж, БОАЖЯ-нд хянуулж, батлуулдаг. Хайгуулын үйл ажиллагаа нь зарим /цар тахал, хорио цээр, орон нутгийн эсэргүүцэл, цаг уур, геологийн нөхцөл зэрэг/ шалтгааны улмаас төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх тохиолдол үүсдэг. Үүнтэй уялдан тухайн хайгуулын ажил хийгдээгүйгээс байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажил хийгдэхгүй байх тохиолдол байдаг. Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13-т заасны дагуу дүгнэх үүрэгтэй байдаг хэдий ч дээрх зарим шалтгааны улмаас дүгнээгүйгээс гэрээлэгч аж ахуйн нэгж биелэлтийн тайлангаа төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах боломж хязгаарлагддаг.

Дүгнэлтийн 5-д:

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу гэрээлэгчдээс гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас учруулсан хохирлыг Ашигт малтмал, газрын тосны газарт барагдуулахыг хариуцагчид даалгахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг тус газраас 2020 оны 12 дугаар сард гарган Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандсан болно. Өнөөдрийн байдлаар нэг ч хэрэг маргаан эцэслэн

шийдвэрлэгдээгүй бөгөөд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.

Ашигт малтмал, газрын тосны газар нь Газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг ханган Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9. "...энэ хуулийн 30, 31, 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх" чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тус газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 1/4287 дугаар албан бичгээр "Шунхлай энерги" ХХК-д БХГ-нд заасан төлбөр урамшууллыг төлөөгүй тохиолдолд холбогдох хуулийн дагуу БХГ-г цуцлах болохыг, 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 3/5573 дугаар албан бичгээр бүх гэрээлэгч компаниудад гэрээний үүргээ биелүүлж ажиллах тухай мэдэгдлийг хүргүүлсэн болно.

Дүгнэлтийн 6-д:

Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3-т "жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх" гэж заасны дагуу гэрээлэгчид жилийн төлөвлөгөө, төсвийг батлуулахаар Төрийн захиргааны байгууллагад төслөө ирүүлдэг. Уг ирүүлсэн төлөвлөгөө, төсвийн төслийг хянан үзэж Газрын тосны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8-т "Төрийн захиргааны байгууллага эхний жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан өдрөөс хойш 120 хоногийн дотор, дараагийн жилээс хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг тухайн жилийн эхний улиралд багтаан батална" гэж заасан хуулийн үүрэгжүүлсэн зохицуулалтын хүрээнд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг тухайн жилийн эхний улиралд багтаан батлах үйл ажиллагаа хийгдэж байна. Гэвч тухайн жилд төлөвлөгөө, төсөв тасрах тохиолдлууд нэлээдгүй гардаг. Голлох хөндлөнгийн шалтгаан нөхцөлүүдээс дурдвал: Орон нутгийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллагууд, иргэдийн эсэргүүцэлтэй тулгарах, төлөвлөгөөт үйл ажиллагаанд хууль бусаар саад учруулах тохиолдол дийлэнх хувийг эзэлж байна. Үүнээс улбаалан тухайн асуудлаар шүүхийн маргаан үүссэнтэй холбогдуулан шүүхийн процесс ажиллагаанаас үүдэн төлөвлөгөө тасрах, хэрэгжилт унах тохиолдол үүсэж байна. Дээр дурдсан голлох суурь шалтгаан нөхцөлүүдийг Төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч урьдчилан таамаглах боломжгүй бөгөөд гарч болзошгүй гэдэг байдлаар төлөвлөгөө, төсвийг батлах нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх үндэслэл болно гэж үзэж байна.

Дүгнэлтийн 7-д:

АМГТГ нь Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, Газрын тосны бүртгэл тооцооны журмын 11 дүгээр хэсэгт үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардалд хяналт шалгалт гүйцэтгэж байна. Одоогийн мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүдэд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хугацааг тодорхой заагаагүй бөгөөд Газрын тосны бүртгэл тооцооны журамд өөрчлөлт оруулах замаар хугацааг тодорхой болгох шаардлага гарч байна.

Дүгнэлтийн 8-д:

АМГТГ нь Газрын тосны тухай хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан чиг үүргийн дагуу газрын тостой холбогдох үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажилладаг. Гэрээлэгчдэд зориулан манай газраас албан ёсны цахим хаяг нээж өгсөн бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллээ тогтмол ирүүлдэг /гэрээлэгч@mgrat.gov.mn/. Эдгээр ирүүлсэн мэдээллүүдэд чиглэл, чиглэлийн

дагуу хариуцсан мэргэжилтнүүд нь хяналт тавин удирдлагыг мэдээллээр ханган ажилладаг. Тухайн хариуцсан мэргэжилтэн бүр өөрийн чиглэлийн мэдээллийг боловсруулан фонд үүсгэн цахим хэлбэрээр хадгалдаг. Хайгуулын үйл ажиллагаагаа дууссаны дараа ирүүлсэн тайлангуудыг тухайн жилийн төлөвлөгөө, төсөв, өдөр тутмын мэдээ зэрэгтэй харьцуулан хяналт тавьдаг. Гэрээлэгч тайланд өдөр тутмын цахимаар ирүүлсэн мэдээ, өрмийн ажил эхлэх болон дуусах мэдэгдэл зэрэг чухал баримтуудыг тайланд хавсралт болгон ирүүлдэг. Цар тахалтай холбоотойгоор хайгуулын талбай дээр хяналт тавих ажил тодорхой хэмжээнд саатсан ч шаардлагатай хэмжээнд хяналт тавин ажиллаж байна. Мөн тайлан мэдээг хүлээн авах, хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулах үүднээс газрын тосны талбайн нэгдсэн мэдээллийн цахим систем-программтай болох асуудлыг хэлэлцэж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Дүгнэлтийн 9-д

АМГТГ-ын даргын 2022 оны 120 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хайгуулын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн 2021 оны, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн 2019-2021 оны өртөг нөхөгдөх зардлыг хянах шалгалтыг эхлүүлсэн. 2013-2017 оны татварын маргааны асуудлаар болон татвар, гаалийн татварын асуудлаар 2 байгууллагын хамтарсан хяналт, шалгалт хийгдэж байгаа гэсэн үндэслэлээр хяналт шалгалтыг хойшлуулах хүсэлтийг ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдээс ирүүлсэн. Ажлын хэсэг өртөг нөхөгдөх зардлын хяналт шалгалтыг 2022 оны 3-4 дүгээр улиралд багтаан дуусгахаар ажиллаж байна. Гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардалд баталгаажсан ӨНЗ-ын дүнгээр ӨНЗ-ын тайланд залруулга хийх бөгөөд залруулга хийх дүн нь төрийн аудитын байгууллагын аудитаар баталгаажсан дүн байна.

Зөвлөмжийн 3-т:

Монголын алт /МАК/ ХХК, Макс ойл ХХК, Петроматад ХХК-ийн 2020 онд гаргасан зардал нь 2019 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын төлбөрийн төлөлт бөгөөд ковид цар тахлын улмаас эдгээр гэрээлэгчдийн 2020 оны хайгуулын хугацааг түр зогсоосон. "Газрын тосны бүртгэл тооцооны журам"-ын 11.2-т "Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны нь байгууллага нь гэрээлэгчийн **батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, хуваарилалтын тайланг анхан шатны баримт материалд үндэслэн хянан шалгаж, дүгнэлт гаргана**" гэж заасан, мөн тус журмын 3.1.30-д хайгуулын үйл ажиллагаа түр зогссон хугацаанд гарсан зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй байхаар тусгасан. Иймд дээр дурдсан гэрээлэгчдийн 2020 онд төлсөн 2019 оны хайгуулын ажлын төлбөрийг гэрээлэгчдийн 2019 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд хамруулсан болно.

Зөвлөмжийн 7-д

Хайгуулын үйл ажиллагааг зогсоосон хугацаанд байгаль орчны хамгаалах ажил гүйцэтгэх, үргэлжлүүлэх шаардлага үүсдэг бөгөөд Газрын тосны бүртгэл тооцооны журмын 3 дугаар хэсгийн 3.1.25 "гэрээлэгч, эсхүл оператор компани өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас байгаль орчин бохирдуулсныг нөхөн сэргээх зардал, холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгээгүй байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зориулсан зардал;"-ыг мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтэд үндэслэсэн байх, мөн тус журмын 3 дугаар хэсгийн 3.1.30 "хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа түр зогссон хугацаанд гарсан зардал;"-ыг байгаль хамгаалахтай холбогдон гарсан үед хамааруулах эсэхийг эргэн харах шаардлагатай гэж үзэж байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний хавсралтад заасан хайгуулын ажлын доод хэмжээ, тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөсөн хэмжээ зэргээс хамаарч байгаль орчинд үүсэх нөлөөллийг хянах, бууруулах, нөхөн сэргээх ажлыг төлөвлөж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, БОАЖЯ-нд хянуулж, батлуулдаг. Өөрөөр хэлбэл хайгуулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулдаг.

Иймд дээрх тайлбар үндэслэл, саналыг аудитын дүгнэлт, зөвлөмж, шаардлагад тусгаж өгөхийг хүсье.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АМГТГ-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Санал	Хариу тайлбар
Дүгнэлт 1-д	Гэрээлэгч бүрээр ӨНЗ-ын дэлгэрэнгүй задаргаагаар санал авсан.
Дүгнэлт 2-т	Аудитаар АМГТГ-т Зөрчлийн тухай хуулийн 9.10 дугаар зүйлийн 1.2-т заасны дагуу хариуцлага тооцох эрх бүхий байгууллагад шилжүүлж, БХГ-д заасны дагуу хариуцлага тооцож ажиллах, албан шаардлагыг хүргүүлж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
Дүгнэлт 4-т	Дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Дүгнэлт 5-д	Дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Дүгнэлт 6-д	Дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Дүгнэлт 7-д	Аудитаар АМГТГ-аас гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, ӨНЗ зэрэгт хяналт шалгалт хийсэн тайланг ТАБ-д хүргүүлэх хугацааг тодорхой болгох зөвлөмжийг МУЗГ-т хүргүүлж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
Дүгнэлт 8-д	Аудитаар АМГТГ-т гэрээлэгчдийн ӨНЗ-ын тайлан болон хяналт шалгалтын тайлангийн загвар, тайланг хүлээн авах, хүргүүлэх зэргийг тогтсон загварт оруулж журамлах зөвлөмжийг хүргүүлж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
Дүгнэлт 9-д	Аудитаар АМГТГ-т 1-2 санхүүгийн жилээр хугацаа хоцролттой байгаа зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
Зөвлөмж 3-т	2020 онд зарцуулсан зардлын гүйлгээг “он дамнасан зардал” гэсэн нэршлээр 2019 оны ӨНЗ-д оруулж тооцсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 3.1.2-т заасантай нийцээгүй байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
Зөвлөмж 7-д	Аудитаар АМГТГ-т Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу хариуцлага тооцох эрх бүхий байгууллагад шилжүүлж, БХГ-д заасны дагуу хариуцлага тооцож ажиллах, албан шаардлагыг хүргүүлж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 дугаар сарын 08 № 01/А0150046
АХГ-2022/10-НА-СТА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашигт малтмал газрын тосны газар нь 2022 оны 12 дугаар сарын байдлаар Капкорп Монголиа ХХК-аас 75,000.0 ам.доллар, Шунхлай энерги ХХК-аас 1,716,130.7 ам.доллар, Монголын Алт ХХК-аас 113,079.7 ам.доллар, Макс ойл ХХК-аас 2,895,492.8 ам.доллар, нийт нийт 4,799,703.2 ам.долларын төлбөр, урамшуулал, үйлчилгээний дэмжлэгийг холбогдох төсвийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т "... энэ хуулийн 30, 31, 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх нэр бүхий гэрээлэгч компаниудаас нийт 4,799,703.2 (дөрвөн сая долоон зуун ерэн есөн мянга долоон зуун гурван ам.доллар хорин цент) ам.доллар Үндэсний аудитын газрын Төрийн сан банк дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

Z:\Akt\2023\0208\SNAG-1.Docx

0001090499

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит

2. Актын биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ОТГОНБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 08 № 01/А 0140054

Улаанбаатар хот

АХГ-2022/10-НА-СТА

Г Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашигт малтмал газрын тосны газар нь 2021, 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, холбогдох зардал, тайланг хянаж шалгасан тайланг 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, хуульд заасан хяналт шалгалтын ажил 2-3 санхүүгийн жилийн хоцролттой байна.

Үүнээс шалтгаалан Сангийн сайдын 2020 оны 46 дугаар тушаалаар баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, нэгтгэлийн мэдээллийн ашиглах журмын 4.3-д заасны дагуу гэрээлэгчид жилийн эцсийн санхүүгийн тайландаа дараа оны 12 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл залруулга хийх хугацаа өнгөрч, Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу ТАБ аудит хийж, баталгаажуулсан дүнгээр гэрээлэгчид санхүүгийн тайландаа "...хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо..." зэргийг залруулж баталгаажуулах боломжгүй байдлыг үүсгэж байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын 11.6-д тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ашигт малтмал, газрын тосны газрын холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар-т ирүүлэхийг Монгол Улсын Их хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадагва нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023

оны

02

дугаар сарын

08

№

08/A0150046

Улаанбаатар хот

АХГ-2022/10-НА-СТА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6, БХГ-ний 14.1.2¹ /Номгон IX/, 15.1.2 /Богд IV, Онги V, Матад XX/-т заасныг зөрчин 2020 онд Жи Өү Эйч ХХК Номгон IX талбайд 433,159.4 ам.доллар, 2019 онд Жи Өү Эйч ХХК Номгон IX талбайд 667,262.5 ам.доллар, Капкорп Монголиа ХХК Богд IV талбайд 96,105.3 ам.доллар, Онги V талбайд 96,299.6 ам.доллар, Петроматад ХХК Матад XX талбайд 281,047.6 ам.доллар нийт 1,573,874.4 ам.долларын өртөг нөхөгдөх зардлын гүйлгээг гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн байхад Ашигт малтмал, газрын тосны газар нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж, гэрээлэгчдэд хариуцлага тооцож ажиллаагүй байна.

Энэ нь Газрын тосны бүртгэл тооцооны журмын 11 дүгээр зүйлийн 11.1², Бүтээгдэхүүн хуваах гэрээний 3.1.1³, 19.1.2⁴ /Номгон IX/, 20.1.2 /Богд IV, Онги V, Матад XX/-т заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийт 1,573,874.4 ам.долларын өртөг нөхөгдөх зардлын гүйлгээг гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэж хууль, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэрээлэгчдийг Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.13-т заасны дагуу эрх

¹ гэрээлэгч эсхүл оператор компани нь хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгана.

² Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Газрын тосны тухай хуулийн 9.1.3, 9.1.8, 9.1.10, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, зарцуулсан зардал, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардал, төлбөр урамшгэлийн төлөлт, борлуулсан газрын тосны орлогын тооцоог үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавьж ажиллана."

³ Газрын тосны тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан дэмжлэг үзүүлж, хяналт тавих;

⁴ Гэрээлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу удаа дараа ноцтой зөрчсөн, уг зөрчлийг арилгах талаар төрийн захиргааны байгууллагаас тогтоож өгсөн хугацаанд арилгаагүй буюу арилгаж эхлээгүй;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26430


Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит

бүхий байгууллагад шилжүүлэн, хариуцлага тооцож, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ОТТОНБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 08 № 03/А0150046
АХГ-2022/10-НА-СТА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашигт малтмал газрын тосны газар нь 2021, 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, холбогдох зардал, тайланг хянаж, шалгасан тайланг 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, хуульд заасан хяналт шалгалтын ажил 1-2 санхүүгийн жилийн хоцролттой байна.

Үүнээс шалтгаалан Сангийн сайдын 2020 оны 46 дугаар тушаалаар баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, нэгтгэлийн мэдээллийн ашиглах журмын 4.3-д заасны дагуу гэрээлэгчид жилийн эцсийн санхүүгийн тайландаа дараа оны 12 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл залруулга хийх хугацаа өнгөрч, Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу ТАБ аудит хийж, баталгаажуулсан дүнгээр гэрээлэгчид санхүүгийн тайландаа "...хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо..." зэргийг залруулж баталгаажуулах боломжгүй байдлыг үүсгэж байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын 11.6-д заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гэрээлэгчдийн 2021, 2022 оны холбогдох үйл ажиллагаанд хуулийн дагуу хийсэн хяналт шалгалтын тайлангаа төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, 1-2 санхүүгийн жилээр хугацаа хоцорсон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 3 дугаар сарын 31-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ОТГОНБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 08 № 05/А0150046

Улаанбаатар хот

АХГ-2022/10-НА-СТА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Газрын тосны бүртгэл тооцооны журмын 10.6 БХГ-ний 14.1.1 /Жи Өү эйч ХХК/, 15.1.1 /Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК/-д тус тус заасныг зөрчин гэрээлэгч Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК-ууд нь газрын тосны хайгуул, ашиглалт, бүтээн байгуулалт, татан буулгалтын үйл ажиллагаанд хамаарах гэрээ, тооцооны хуудас зэрэг санхүүгийн анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийг гадаад хэлээр үйлдэж, бүртгэсэн байхад Ашигт малтмал, газрын тосны газар нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж, гэрээлэгчдэд хариуцлага тооцож ажиллаагүй байна.

Энэ нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний 3.1.1¹, 19.1.2² /Номгон IX/, 20.1.2 /Богд IV, Онги V, Матад ХХ/-т заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийг гадаад хэлээр үйлдэж, Монгол Улсын хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэрээлэгчдийг Зөрчлийн тухай хуулийн 9.10 дугаар зүйлийн 1.2-т заасны дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлэн, хариуцлага тооцож, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

¹ Газрын тосны тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан дэмжлэг үзүүлж, хяналт тавих;

² Гэрээлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу удаа дараа нэцгөй зөрчсөн, уг зөрчлийг арилгах талаар төрийн захиргааны байгууллагаас тогтоож өгсөн хугацаанд арилгаагүй буюу арилгаж эхлээгүй;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ОТГОНБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 08 № 04/А0150046

Улаанбаатар хот

АХГ-2022/10-НА-СТА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрээлэгчид БОАЖС-ын 2019 оны А/618 дугаар тушаалаар баталсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 2.9-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг уялдуулан боловсруулдаггүй, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй зөрчил гаргасан байхад Ашигт малтмал, газрын тосны газар нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж, гэрээлэгчдэд хариуцлага тооцож ажиллаагүй байна.

Энэ нь Газрын тосны бүртгэл тооцооны журмын 11 дүгээр зүйлийн 11.1¹, Бүтээгдэхүүн хуваах гэрээний 3.1.1², 19.1.2³ /Номгон IX/, 20.1.2 /Богд IV, Онги V, Матад XX/-т заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг уялдуулан боловсруулаагүй хууль тогтоомж зөрчсөн гэрээлэгчдийг Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлэн, хариуцлага тооцож, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

¹ Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Газрын тосны тухай хуулийн 9.1.3, 9.1.8, 9.1.10, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, зарцуулсан зардал, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардал, төлбөр урамшууллын төлөлт, борлуулсан газрын тосны орлогын тооцоог үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдал байнгын хяналт тавьж ажиллана.¹⁰

² Газрын тосны тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан дэмжлэг үзүүлж, хяналт тавих;

³ Гэрээлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу удаа дараа ноцтой зөрчсөн, уг зөрчлийг арилгах талаар төрийн захиргааны байгууллагаас тогтоогдсон хугацаанд арилгаагүй буюу арилгаж эхлээгүй;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264330

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ОТГОНБАЯР

